




ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМ



ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ

**ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, УВС АЙМГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ”
ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2022 он



ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, УВС АЙМГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ” ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хянасан:

ХОВД АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА:

Л.БАТБАЯР

ХОВД АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ГАЗАР, ГАЗРЫН ХЭВЛИЙ, НӨХӨН СЭРГЭЭЛТ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

186130601
186130601

Г.МАРАЛМАА

Хэрэгжилтийг гаргасан:

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ”- ИЙН ЗОХИЦУУЛАГЧ:

Ч.ГАНТУЛГА

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ”- ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ ДАРГА:

УЛААНБААТАР УРС 1064
УЛААНБААТАР УРС 1064

Б.МӨНХТУЛГА

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ”- ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:

Б.ЭНХЧИМЭГ

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ”- ИЙН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР, НИЙГМИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

М.БЯМБАСАЙХАН

2022 он

АГУУЛГА

1	ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1	Товч танилцуулга	4
1.2	Төслийн ТЭЗҮ	4
1.3	Барилга, байгууламж.....	5
2	ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
2.1	Уур амьсгал	6
2.2	Газар зүй	6
2.3	Геологи.....	6
2.4	Газар ашиглалт.....	7
2.5	Гадаргын ус.....	7
2.6	Газрын доорх ус.....	7
2.7	Хөрсөн бүрхэвч.....	7
2.8	Ургамалжилт	8
2.9	Ойн сан	8
2.10	Амьтны аймаг	8
2.11	Тусгай хамгаалалттай газар нутаг	9
2.12	Түүх соёлын дурсгалт зүйлс, археологийн олдвор.	9
2.13	Төслийн талбай дахь айл өрхүүдийн нийгмийн байдлын товч тодорхойлолт	10
2.14	Ус хэрэглээ	11
2.15	Химийн бодисын хэрэглээ	11
2.16	Цахилгаан болон дулаан хангамж, агаар сэлгэлт	11
2.17	Хог хаягдал.....	11
2.18	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	12
3	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	13
3.1	Төслийн болзошгүй нөлөөллийг Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга (Checklist)-аар тооцсон үнэлгээ.....	14
4	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	17
5	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
5.1	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний хэрэгжилт	20
5.2	Улиаст багийн төвийн зураг төслийн ажил боловсруулах.....	27
5.3	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах	29
5.4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний бэлтгэл ажил.....	30

5.5	Нөлөөлөлд өртөж буй айл өрхийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын гэрээг хуулийн хүрээнд шийдвэрлэх.....	31
5.6	Нөлөөлөлд өртөж буй айл өрх, түүх соёлын өвийн нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэрэгжилт, явцыг дүрсэн хэлбэрээр танилцуулах.....	32
6	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
6.1	Археологийн түүх, соёлын дурсгалт зүйлс.....	33
6.2	Палентлогийн түүх, соёлын дурсгалт зүйлс.....	35
7	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	37
7.1	Төсөл хэрэгжих тусгай хэрэгцээний газрын харилцааны асуудлаар танин мэдэхүй, соён гэгээрүүлэх ажлыг арилжааны болон орон нутгийн телевизүүд, мэдээллийн сайтуудаар дамжуулан өргөнөөр зохион байгуулах	37
7.2	Тусгай хамгаалалттай газрын аюулгүй байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтын ажил болон ТЖБОМТ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулалтын болон тулгарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн байгууллагатай хамтарч ажиллах.....	37

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөллийн үнэлгээ	13
Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн жагсаалт	14
Хүснэгт 3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	19
Хүснэгт 4. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	33
Хүснэгт 5. БОМТ-г хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	37


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Газарзүйн байршил.....	4
Зураг 2. Ерөнхий төлөвлөгөө	5
Зураг 3. Улиаст багийн төвийн ерөнхий төлөвлөгөө.....	28
Зураг 4. Цэцэрлэгийн зохион байгуулалт.....	28
Зураг 5. Захиргааны байрны зохион байгуулалт.....	28
Зураг 6. Сургуулийн гадаад байгуулалт	29
Зураг 7. Үйлчилгээний төвийн зохион байгуулалт.....	29
Зураг 8. Харагдах байдал.....	29
Зураг 9. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн ерөнхий төлөвлөгөө	30
Зураг 10. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн харагдах байдал	30
Зураг 11. Тахилын байгууламж	34
Зураг 12. Дугуй болон Чулуун дараастай булш	34
Зураг 13. Археологийн тайлан хүлээлгэж өгсөн нүүр	35
Зураг 14. Палеонтологийн тайлан хүлээлгэж өгсөн нүүр	36

1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Товч танилцуулга

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын (УЦС) төслийн байршил нь Ховд хотын төвөөс баруун хойш 120 км, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын төвөөс баруун хойш 20.0 км-т орших Шижигтийн хавцалд байрлана. Төсөл нь Монгол улсын ЗГ-ын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн дугаар 357 тоот тогтоолоор Улсын тусгай хэрэгцээнд авсан 28000 га газрыг хамарна.



Зураг 1. Газарзүйн байршил

Усан цахилгаан станцын төслийн нуур үүсгэх талбай 9871.1 га, жилийн дундаж урсац 69 м³/с. Төслийн үндсэн зорилго нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх юм. Нуурын усан сангийн бүрэн дүүргэлтийн түвшин 1325 м, ашиглалтын доод түвшин 1305 м, усан сангийн нийт нөөцлөх хүчин чадал 1140 сая м³, ашиглагдах хүчин чадал 1101 сая м³, ус нөөцлөх хүчин чадлын коэффициент 47.05% байна. Усан сан нь олон жилийн турш ашиглагдана. УЦС-ын нийт суурилагдсан хүчин чадал 90 МВт. Жилд дундажаар 4061 цаг ажиллаж 366 сая киловатт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ.

1.2 Төслийн ТЭЗҮ


Төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг 1964-1965 онд хуучин ЗХУ-ын Цахилгаан шугам сүлжээ, зураг төслийн институтээс Ховд гол дээр барих усан цахилгаан станцын урьдчилсан ТЭЗҮ хийж, Шижигт хавцлын даланг урьдчилсан байдлаар тооцож хамгийн дээд өндөр нь 75 м, урт нь 300 м, суурилагдсан хүчин чадал нь 95 МВт гэж тогтоосон байна.

2008 онд Монгол улсын ЭХЯ-ны харьяа Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төвийн захиалгаар М-Си-Эс Интернэшнл, Японы Кюшу цахилгаан сүлжээ, Баруун японы инженерийн зөвлөх компаниуд хамтарч хуучин судалгааны ажлын үр дүн, ЗХУ-ын хийсэн далангийн тооцоо, төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг судалж дахин ТЭЗҮ хийсэн. Тус ТЭЗҮ-д даланг “бетон-булдаж нягтруулах технологи”-оор барих саналыг тусгасан. Усан сангийн дээд түвшинг 1325 м, усны урсацыг 136 м³/сек, суурилагдсан хүчин чадлыг 64.2 МВт гэж тооцжээ. 2016 онд Өмнөд Солонгосын Ёошин Инженеринг Компани төслийн ТЭЗҮ-ийг дахин хянаж үзээд даланг “асфальтан булдаж нягтруулах” технологийг санал болгосон байна. Усан сангийн дээд түвшинг 1327 м, суурилагдсан хүчин чадлыг 26 МВт гэж хянажээ.

Төслийн ТЭЗҮ-ийн сүүлийн хувилбарыг БНХАУ-ын Усны нөөцийн хайгуул, зураг төсөл, судалгааны “Бэйфанкомпани” ХХК боловсруулж, 2019 оны 10-р сард Эрчим хүчний яамаар батлуулсан байна.

1.3 Барилга, байгууламж

Төслийн үндсэн барилгад элс-хайрган дүүргэлттэй бетонон хучилттай далан, үерийн усны дээд, доод хаяуур, ус хүлээн авах суваг, цахилгаан станцын барилга орно.



Зураг 2. Ерөнхий төлөвлөгөө

2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Уур амьсгал

Төслийн бүс нутаг нь хуурай сэрүүвтэр зунтай, хахир өвлийн мужид хамаарна. Төслийн бүс нутагт жилдээ 2700-2900 орчим цаг нар гийгүүлнэ. Жилийн дундаж агаарын температурын олон жилийн дундаж утга буюу хэвийн хэмжээ (норм ч гэдэг) $-0.8^{\circ}\text{C} \dots 1.7^{\circ}\text{C}$ орчим байна. Хамгийн хүйтэн 1 дүгээр сард (-22.4°C)-(-24.7°C) хүйтэн байх ба хамгийн дулаан 7 дугаар сард ($+17.1^{\circ}\text{C}$)-($+20.5^{\circ}\text{C}$) дулаан байна. Жилийн дундаж агаарын температурын утга нь $-0.8^{\circ} \div 1.7^{\circ}\text{C}$ орчим байдаг. Хөрсний гадаргын жилийн дундаж температур $0.8^{\circ}\text{C} \dots 4.6^{\circ}\text{C}$ орчим дулаан байна. Жилдээ 75-225 орчим мм хур тунадас унах бөгөөд түүний 80-93% нь жилийн дулаан улиралд (IV-IX сарын хооронд) орно. Жилдээ Алтан Хөхийн болон Цамбагарав уулын өндөрлөг хэсгээр 200 - 225 мм, захын дундаж өндөрлөг уулсаар 125 – 175 мм, голын хөндийд 75-100 мм орчим хур тунадас ордог байна. Үнэмлэхүй чийгшил жилийн дундаж байдлаар дунджаар 4.8 гПа. Харьцангуй чийгшил жилийн дундаж байдлаар 55%-60% орчим болно. Жилийн дундаж салхины хурд 1.0-2.9 м/с орчим, хаврын саруудын салхины дундаж хурд 4 м/с хүрдэг боловч Монголдоо хамгийн салхи багатай газрын нэг юм. Салхины хамгийн их хурд 34 м/с-ээс давж болно.

2.2 Газар зүй

Ховд голын сав газар нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Алтай Соёны уулт Их мужийн Монгол Алтайн мужид хамаарна (Д.Даш).

Ховд гол нь Алтай Таван Богд уулын баруун урьд хажуугийн мөсөн голоос эхтэй хэд хэдэн гол горхиуд цутгах Хотон, Хоргон нуураас эх авч урссаар Хар ус нуурт цутгана. Голын нийт урт 516 км бөгөөд голын 31 км урт хэсэг нь Баян-Өлгий аймгийн Баяннуур, Увс аймгийн Өмнөговь 10 гаруй км нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумдын нутгийг тус тус дайран өнгөрдөг.

Ховд голын хөндийн төрх байдлын хувьд уртын дагуудаа хавтгай ёроолтой ч уулзүй, гадаргуугийн хотгор гүдгэрээс хамаарч өргөний хувьд хавтгай ёроолтой өргөн, хавтгай ёроолтой нарийн хөндий ээлжлэн илрэх төдийгүй зарим хэсэгтээ хөндий бүр нарийссаар хавцал маягийн хөндийг үүсгэдэг онцлогтой. Тухайлбал Ховд голын хөндий нь нэр дурдсан 3 аймгийн 4 сумдын нутгийг баруунаас зүүн тийш дамнан цувраа үргэлжилсэн уулсыг хойноос урагш зүсэн гарах богиновтор огцом тохойролт дээр нарийн хавцлын хэв шинжид шилждэг. Харин уул нуруудын ар өврөөр голын хөндий өргөн уудам болж ирдэг.

Ховд гол нь Төв Азийн гадагш гарах урсацгүй голуудын дотроос хамгийн элбэг устай нь бөгөөд гол дагуу Шижигтийн хавцлаас эхлэн дээш д.т.д 1230-1325 м-ийн өндөршилд хамаарах хөндийн хэсэгт “Эрдэнэбүрэнгийн УЦС барих” төсөл хэрэгжих юм.

2.3 Геологи

Тус газар нэлэнхийдээ Палеозойн настай боржин чулуулаг тархсан. Эдгээр чулуулаг нь аллюви болон делювийн хурдас, элэгдмэл элс, салхины болон мөстлөгийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдсуудаар бүрхэгдсэн. Талбайд үндсэн чулуулаг нь боржин юм. Үндсэн чулуулгууд дээр интрузив чулуулаг тархсан байна. Дөрөвдөгчийн хурдас Аллюви (а-Q2), Эрдэнэбүрэн формаци (O3-S1eb) тархсан.

Тектоник: Төслийн сонгосон талбар нь газар хөдлөлийн өндөр бүсэд ордог ба Монголын Барилгын Норм ба Дүрэм 2-01-01-ийн дагуу тус газар нутаг нь Рихтерийн шатлалаар газар хөдлөлийн 92 баллаар хэмжигдсэн байна.

Газар хөдлөлт. Эрдэнэбүрэнгийн УЦС баригдах орчин газар хөдлөлтийн IX зэрэглэлийн бүсэд буюу тектоник тогтворжилт сул бүсэд багтана.

2.4 Газар ашиглалт

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын тусгай хэрэгцээнд авсан 28000 га талбайн 10448 га буюу 37.3 хувь Баяннуур суманд, 12297 га буюу 43.9 хувь Өмнөговь суманд, 4693 га буюу 16.8 хувь нь Мянгад суманд, 545 га 1.9 хувь нь Эрдэнэбүрэн суманд хамаарагдаж байна.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын усанд автах талбайд нийт 9871.1 га нутаг дэвсгэр хамарч байгаа бөгөөд үүнээс усан сангийн талбайд Өмнөговь суманд 4558.6 га буюу 46.4%, Баяннуур суманд 5176.1 га буюу 52.4%, боомтын талбайд 4 сумын 136.4 га талбай хамаарагдана.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн Тусгай хэрэгцээний талбай 28000 га талбайд Өмнөговь сумын нутагт 125 өвөлжөө, Мянгад сумын нутагт 5 өвөлжөө, Эрдэнэбүрэн сумын нутагт 3 өвөлжөө, Баяннуур сумын нутагт 150 өвөлжөө хаваржаа байрлаж байна.

Харин усанд автах талбайд Баяннуур сумын 145 айлын өвөлжөө хаваржаа (1 бага сургуулийн барилга), 1 мод үржүүлгийн газар, 22 нэгж талбарт хадлан болон ногооны талбай, 102 гар худаг, Өмнөговь сумын 125 өвөлжөө хаваржаа, 1 багийн төвийн 17 барилга объект, 3 худаг байршиж байгаа бөгөөд тус сумын Мөргөлжин аралд Баяннуур сумын 26 өрх суурьшин амьдарч байна.

2.5 Гадаргын ус

Ховд гол нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах бөгөөд Монгол орны цэнгэг устай хамгийн том Таван Богд уулсын мөстлийн массив, мөсөн голуудаас эх аван, Монгол Алтай нурууны өндөр уулс дундуур урсан Хар-Ус нуурт цутгаж, Хар, Ногоон, Дөргөн, Айраг, Хяргас зэрэг Их нууруудын хотгорын нууруудад хүрч, цутгана. Ховд бол 6 дугаар эрэмбийн гол. Ховд голын урт 596 км, хэвгий 0.0035, ус хурах талбай 59139 км². Ховд гол-Баяннуур харуулын ус хурах талбай 40993 км², УЦС-ын чиглэлээр 45500 км² буюу эдгээрийн зөрөө 10% байна. Ховд-Баяннуур харуулын жилийн дундаж урсацын норм 64.7 м³/с буюу 2041.5 сая м³ усны нөөцтэй. Жилийн дундаж урсац 20 жилд 1 удаа тохиох магадлалтай 5%-ийн хангамшилтай элбэг услагтай жилд 93.2 м³/с байна.

2.6 Газрын доорх ус

Төсөл хэрэгжих талбайн хэмжээнд гидрогеологийн давхарга зүйн ангиллын хувьд голоцены настай голын гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст давхарга-(Q2), плейстоцен-голоцен настай бэл-хормойн, голын гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст давхарга-(Q1-2), ордовик-силурын настай гүний гарал үүсэлтэй чулуулгийн ан цавын усажсан бүсийн газрын доорх ус-(O-S) тархана. Энэхүү усажсан ан цавын бүсийн зузаан нарийвчлан тогтоогдоогүй бөгөөд газрын доорх ус ихэнхдээ чөлөөт гадаргуутай, ардын болон бага гүнтэй инженерийн худгийн мэдээллээр уст үеийн илрэх гүн 0.8-5.0 м, ундарга 0.1-1.0 л/с болно. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын усан сангийн нийт талбайн хэмжээ нь 9758.7 га буюу 9.8·10¹⁰ м² болно. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын усан сан байгуулах талбайн хэмжээнд 16282.5 м³/хоног буюу 190.4 л/сек хэмжээтэй газрын доорх ус нөөцлөгдөн үлдэнэ.

Усан санд ус хуримтлуулах явцад 14 000 000 м³ хэмжээтэй ус усан сангийн ёроолоор доош шүүрүүлж алдах магадлалтай болно. Усан сангийн нийт идэвхтэй эзлэхүүн 1 140 000 000 м³ ба усаар ханаагүй сэвсгэр хурдасны нүх сүв болон үндсэн чулуулгийн ан цавын орон зайг дүүргэхэд нөхөн тэжээгдлийн хэмжээ 14 000 000 м³ байгаа тул усан сангийн нийт идэвхтэй эзлэхүүний 1.2% нь тодорхой хугацаанд доошоо нэвчин алдсаны дараа хөрс нь усаар бүрэн ханах буюу усан сан д.т.д 1325 м-ийн түвшинд усаар дүүрэх хугацаа 1.2%-иар нэмэгдэх болно.

2.7 Хөрсөн бүрхэвч

Монгол Алтайн нурууны хөрс бүрэлдэн тогтох үйл явцад газрын хотгор, гүдгэр, ар өвөр хажуугийн тогтоц, уур амьсгалын эрс тэс байдал тодорхой нөлөөлж, хөрсний босоо бүслүүр

үүссэн байдаг онцлогтой ба талбайн хэмжээнд тогтворжсон хөрсийг ерөнхийд нь уул-хөндийн чулуурхаг хүрэн болон голын эрэг татмын чийгт гарлын аллювийн гэж хуваав.

Талбайн хэмжээнд уулын орой хяр, энгэр хажуугаар хүрэн хөрсний төрлүүд болох уулын нимгэн давхаргатай чулуурхаг цайвар хүрэн, чулуун хучаастай чулуурхаг цайвар хүрэн, сайргархаг цайвар хүрэн, харин уулын хормой бэл, хөндийдээ сайргархаг цайвар хүрэн хөрс тогтворжих ба эндээс чулуун хучаастай сул хөгжилтэй элсэн хөрс харьцангуй их тархалттай. Уулын хөрс нь өнгөн гадаргадаа ямагт чулуутай, ялзмагт давхаргын зузаан 6-15 см, нимгэн бөгөөд том жижиг чулуу их агуулсан, чулуу нь хурц өнцөгтэй, ихэнхдээ элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ялмагийн агууламж 0.20-1.41% буюу бага, орчин рН 7.17- 8.98 буюу шүлтлэгээс их шүлтлэг шинжтэй, дээд давхаргад карбонат бага хэмжээгээр агуулсан онцлогтой.

Голын дагуу түүний эрэг татмаар аллювийн, аллювийн нугын, аллювийн нугат-намгийн, аллювийн намгийн хөрс тогтворжих бөгөөд механик бүрэлдэхүүний хувьд элсэн, элсэнцэр болон хайрга зонхилсон хөнгөн бүтэцтэй. Энд дунд болон бүдүүн ширхэгтэй элсэн фракц 85-90%-ийг бүрдүүлж байгаа бол шавар фракц (0.01 мм) бага ба 5.4-6.6-10.1% хүрнэ. Хөрсний ялзмагт үеийн зузаан 25-35 см ба хэлбэлзэлтэй, орчин багаас (рН 7.74-8.82) их шүлтлэг, ялмагийн агууламж (0.32-1.45%) бага. Голын татмын ус чийг байнгын ихтэй булан тохой, хотосдуу хэсгүүдээр аллювийн намгархаг хөрстэй. Солилцоот сууриудын нийлбэр багатай, сууриудаас магни Mg^{++} болон кальц Ca^{++} ион ээлжлэн зонхилно. Хөрсөнд ургамалд хялбар ашиглагдах P_2O_3 , K_2O -ийн хангамжаар бага.

2.8 Ургамалжилт

Бүс, бүслүүрийн хувьд Шижигтийн хавцал, хавцлаас хойш голын хөндий орчмын нутагт цөлжүү хээр зонхилж байна. Голын татамд чийгсэг бүслүүрийн бус ургамалжилт зонхилж байна. Ургамалжилтын ангиллын хувьд энд хээр, цөл, татмын нуга, татмын чийгсэг ой ба чийгсэг сөөг гэсэн ургамалжилтын үндсэн хэв шинж зонхилно.

Шижигтийн хавцал, Ховд голын сав дагуу нийт 19 овогт хамаарах 48 төрөл, 61 зүйл ургамал байна. Үүнээс хамгийн өргөн тархалттай овгуудад Asteraceae, Fabaceae, Amarantaceae, Poaceae, Juncaceae зэрэг овгийн төлөөлөгчид байгаа ба төрлийн хувьд Artemisia, Caragana, Carex, Oxytropis, Stipa, Agropyron зэрэг төрлүүд зонхилно. 3 зүйл ховор ургамал байгаа ч тохиолдоц хэлбэрээр тааралдана.

2.9 Ойн сан

Шижигтийн хавцалын өмнөд ба хойд хэсгийн Ховд голын дагуух бургас зонхилсон шугуйн одоогийн төлөв байдлыг тооцож үзэхэд нийтдээ 884 га талбайтай, 23868 м³ нөөцтэй бургас (80%), улиасан (20%) ой байна. Хавцалын өмнөд хэсгийн Ховд гол дагуух баруун зүүн эрэгт бургас, улиасан ойн улиас нь 5-7 м дундаж өндөртэй, 20-45 см дундаж диаметртай байна.

2.10 Амьтны аймаг

Төслийн талбайд тархсан болон тархах боломжтой 31 зүйлийн хөхтөн амьтад, 157 зүйлийн шувууд, 5 зүйлийн мөлхөгчид болон олон тооны шавжийн биологийн төрөл зүйлүүд тархан байна. Ховд гол дагуу ойр хавь, Тагийн улаан, Улиастайн шил зэрэг газруудаар цоохор ирвэс, янгир ямаа, халиун буга, чоно, үнэг, хярс, мануул, заарт харх зэрэг хөхтөн амьтадтай.

Хавцлын баруун зүүн талын уулсад янгир, аргал, шилүүс, хадны суусар, саарал чоно зэрэг ховор амьтад байхаас гадна уулын тагийн бүсэд өндөр уулын шарга хайруулдай, галсүүлт, уулын цэгцгий, шийхнүүхэй, хадны жижир зэрэг шувууд байна. Мөн өндөр уулын хадан хясаа бүхий газруудад нөмрөг тас, ёл, цармын бүргэд, шилийн сар элбэг. Энд цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой, рашааны могой зэрэг нь элбэг, түгээмэл тархалттай юм.

Төслийн талбай түүний ойр орчмын нутагт нийт 19 багийн 30 овгийн 199 зүйл х амьтан байгаагаас хөхтөн амьтдын 5 багт хамаарах 14 овгийн 37 зүйл, шувуудын 12 багийн 35 овгийн 157 зүйл, мөлхөгчдийн 2 багийн 4 овгийн 5 зүйл байна.

Монгол улсын Амьтны тухай хуулийн (2012) Нэн ховор амьтны жагсаалтад төсөлд хамрагдах нутагт тархсан амьтдаас цоохор ирвэс (*Panthera uncia*), азийн минж (*Castor fiber*), борцгор хотон (*Pelicanus crispus*), цагаантолгойт ямаансүүл (*Oxyura leucoserphala*), усны нөмрөгбүргэд (*Aquila clanga*) зэрэг хөхтөн амьтад, шувуудтай.

Талбай түүний ойр хавьд байгаа амьтдаас “Зэрлэг амьтан, ургамлын аймгийн Ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд Худалдаалах тухай Конвенци (CITES)”-ийн I хавсралтад цоохор ирвэс, II хавсралтад аргаль хонь, шилүүс мий, мануул мий зэрэг амьтад бүртгэгдсэн байдаг. Түүнчлэн хөхтөн амьтдаас аргаль хонь (*Ovis ammon*), янгир ямаа (*Capra sibirica*), цоохор ирвэс (*Uncia uncia*), эрээн хүрнэ (*Vormela peregusna*) зэрэг зүйлүүд Монгол улсын Улаан ном (1997)-нд бүртгэгджээ.

Загас, усны амьтан. Ховд голын урсгал хүчилтөрөгчийн хангамж сайтай, цэнгэг зөөлөн ус, ёроолын хурдасны олон хэв шинжээрээ хадран ба алтайн сугасны төрлийн загаснууд, сахалт эрээлжийн байршил, үржил-идээшлэлтийн зам газар болж байдаг. Ховд голд 6 зүйл загас амьдарна. Үүнд: Монгол хадран, шивэр хадран ба Алтайн сугасны төрлийн нохой ба шар сугас, давжаа сугас загас тус ай савын унаган загас төдийгүй агнуурын үндсэн загаснууд юм. Сахалт эрээлж нь усны ёроол орчмын амьдралтай, жараахайн загас юм.

Харин ёроолын амьтнаас хавцлын дээд хэсгийн чулуу хайрган хурдастай ёроолын хурдсанд соно (*Odonato*), өдөрч (*Ephemeroptera*), хаварч (*Plecoptera*), манцуйт (*Trichoptera*) шавжийн авгалдайнууд, голоос салаалсан татуурга салаануудад шаалий хавч (*Gammaridae*), усны бясаа (*Hemiptera*) зонхилно.

Сэжигтийн хавцлын хэсэгт голчлон хадран загас үржлийн цугларалт үүсгэж байгаад үрждэг. Хар, Хар-ус нуурын хадран загасны үржлийн сүрэг Ховд голын урсгал сөрж нүүдэллэн 5-р сарын сүүлчийн хагасаас 6-р сарын дунд үе хүртэлх хугацаанд усны урсгал багатай хэсгийн бүдүүн ширхэгт элс хайрга, чулуун хурдас дээр түрсээ шахна. Түрсний хөгжлийн хугацаа байгалийн нөхцөлд 23-30 хоног бойжиж жармагай гардаг.

2.11 Тусгай хамгаалалттай газар нутаг

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц байгуулахаар тусгай хэрэгцээнд авсан 28000 га талбай нь улсын тусгай хамгаалалттай газар болох Алтан Хөхий уул БНГ-аас 0.86 км зайд оршдог, Цамбагарав уул БЦГ-тай 19.9 км-ээр хил залгасан, Сартугтайн Ховд аймгийн Мянгад сумын Орон нутгийн ТХГН-тай талбайн давхцалтай байна. Давхацсан талбайн хэмжээ 4813.64 га байна.

2.12 Түүх соёлын дурсгалт зүйлс, археологийн олдвор.

Тусгай хэрэгцээний газрын усан сан, УЦС-ын барилга байгууламж, замын болон эрчим хүч дамжуулах трассын дагууд 2022 онд эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнд улсын тусгай хэрэгцээнд авсан талбай болон түүний орчмоос нийт 2121 археологийн дурсгал (тусгай хэрэгцээт талбайд 1924)-ыг бүртгэн баримтжуулснаас Увс аймгийн Өмнөговь сумын нутагт 833 (тусгай хэрэгцээт талбайд 644), Ховд аймгийн Мянгад сумын нутагт 220 (тусгай хэрэгцээт талбайд 219), Эрдэнэбүрэн сумын нутагт 98 (тусгай хэрэгцээт талбайд 96), Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт 970 (тусгай хэрэгцээт талбайд 965) дурсгалыг тус тус илрүүлэн бүртгэсэн байна. Эдгээр археологийн дурсгалууд нь он цагийн хувьд урьдчилсан байдлаар 5000 жилийн тэртээгээс буюу шинэ чулуун зэвсгийн үеэс өдгөө ХХ зууныг хүртэлх өргөн хүрээг хамрах бөгөөд чулуун зэвсгийн бууц суурин 3, хүрлийн үеийн булш, хиргисүүр 1687, тахилын байгууламж 44, буган хөшөө 2, хөшөө чулуу 76, хадны зураг 8, хүннү булш 94,

үйлдвэрлэлийн газар 2, түрэгийн үеийн тахилын байгууламж 22, монгол булш 71, хадны оршуулга 3, XIII-XVII зууны үед холбогдох хийдийн туурь 1, төвөд бичээс 3, орчин үеийн оршуулга 1, он цаг тодорхойгүй дурсгал 104 тус тус багтана.

Соёлын биет бус өв, антропологи. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн хүрээнд хамрагдах Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Баян-Өлгий аймгийн Баяннуур, Увс аймгийн Өмнөговь сумдын хүн ам зүйн байдлыг авч үзвэл Эрдэнэбүрэн сум 680 өрхийн 2479 хүн амтай ба үүний 89% өөлд, 7% нь казак үндэстэн, 4% нь бусад ястнууд байгаа бол Мянгад сум 944 өрхийн 3684 хүн амтай, үүний 77% нь мянгад ястангууд болно. Харин Баяннуур сум 1100 өрхийн 5200 гаруй хүн амтай ба 100% казак үндэстэн амьдардаг. Увс аймгийн Өмнөговь сумын 2018 оны байдлаар 1185 өрхийн 4681 хүн амтай ба 98 хувь нь дөрвөд, 2% нь баяд, сартуул, хотон, мянгад, урианхай зэрэг ястнууд байгаа болно.

Судалгаанаас үзвэл тухайн сумуудад зонхилж байгаа казак үндэстэн, өөлд, дөрвөд, баяд, мянгад ястнуудын угсаа гарал, аж ахуй, шашин шүтлэг, оюуны соёлын хүрээ нь өөр өөрийн онцлогтой боловч түүхийн урт удаан хугацааны явцад бие биедээ ижилдэн нэгдсэн, үндэстэн ястан хооронд онцын зөрчилгүй аж төрж, угсаатны бичил бүлгүүд нь “язгуур урлаг” соёлоо хадгалж ерөнхийдөө монголжиж байжээ.

Өөрөөр хэлбэл эдгээр үндэстэн, ястны өв соёл нь Монгол угсаатны соёл бүрэлдэн тогтоход нэгэн цөм болсоор иржээ. Эрдэнэбүрэнгийн УЦС баригдаж ашиглалтанд ороход эдгээр үндэстэн ястны ахуй, соёлд нэгдсэн байдлаар эерэг нөлөө үзүүлэхээс бус, тэдний ёс заншил, шашин шүтлэг, соёлын биет бус өвд нөлөөлөх сөрөг нөлөөлөл харагдахгүй байна.

Энэ нутгийн соёлын биет бус өвийг тээгч настан буурлуудын өмнөх үеэсээ авч үлдсэн, хойч үедээ өвлүүлэн үлдээхээр чармайж буй уламжлалт зан үйл, хөгжим дуу хуур, туульс, бие биелгээг зааж сургах ажил гэр бүлийн хүрээнд төдийгүй хот айл, баг, сумын хэмжээнд өргөн хүрээнд олон хэлбэрээр явагдаж иржээ.

2.13 Төслийн талбай дахь айл өрхүүдийн нийгмийн байдлын товч тодорхойлолт

Төсөл хэрэгжих дээрх талбайн ихэнх нь сумдын ХАА-н эдэлбэр буюу малын бэлчээр, хадлангийн газар, малчид өвөлжиж хаварждаг нутаг юм. Тэд ундны усаа голоос авч, малаа ундаална.

УЦС-ын усан сангийн талбайд Өмнөговь сумын Улиастай багийн төв, гол дагуух байнгын тогтвортой өвөлжиж хаварждаг энэ багийн 90 айл, сумын төвд оршин суудаг боловч энд өвөлжөө, хаваржаатай 18 айлаас гадна багийн төв дээр амьдардаг малчин голдуу 17 айл, нийт 125 айл амьдарна. Эдгээр айлууд нийт 36558 толгой малтай, түүний 70% буюу 25600 нь бог мал байна.

Харин голын баруун талын салаа татуурга, арлуудаар Баяннуур сумын Цэцэгт багийн 119, Баяннуур багийн 10, Шар цэхээ багийн 16 малчин айл мөн л тогтвортой өвөлжиж хаваржиж ирсэн. Эдгээр айлууд 25846 толгой малтай, түүний 91.5% буюу 23650 нь бог мал байна. УЦС-ын усан сан байгуулах талбайд нийт 270 малчин айл өрх, тэдний өвөлжиж хаваржиж ирсэн нутаг, бэлчээр, хадлангийн эдэлбэр газар бүрэн хэмжээгээр хамрагдаад байгаа болно.

2021 байдлаар Ховд гол дагуу Баяннуур сумын төв, Цэцэгт багийн айлууд хоорондоо ойрхон байх ба харин Улиаст багийн төвөөс Өмнөговь сумын төв хүрэхэд 75 км зайтай, хөрсөн замтай. Энэ хоёр сум, нэр дурдсан багийн төвүүд эрчим хүчний сүлжээнд бүрэн холбогдсон.

Ховд гол дагуу 32 км урт зурваст 884 га талбайд бургасан шугуй, улиас хайлаас, чацарганы төгөл, харгана зонхилсон ойтой. Малчид бургасыг хашаа саравчаа барих, гэрийн хана унь, шээзгий хийх, унанги хэсгийг түлшинд хэрэглэх зэргээр ашиглаж ирсэн. Гол дагуу Цэцэгт багийн малчдын чацаргана, зарим хүнсний ногоо, хөх тариа тарьж ирсэн хэд хэдэн хэсэг талбайнууд бий.

2.14 Ус хэрэглээ

Барилгын ажлын үеийн усны хэрэглээг Ховд голоос, ашиглалтын үеийн ус хэрэглээг усан сангаас УЦС-д ирж буй уснаас тус тус хангана. Барилгын ажлын үеийн гол ус хэрэглээ нь бетон зуурмаг бэлтгэхэд зарцуулагдах ба энэ үе шатанд 95400.0 м³/жил ус, зам талбайн усалгаанд жилд 32800.0 м³ ус хэрэглэнэ.

Ашиглалтын үед усны хангамжийн нэг системтэй байх ба энэ нь техникийн болон унд ахуйн усны системүүдээс бүрдэнэ. Ус хадгалах савны багтаамж 250 м³, үүний 191 м³ гал унтраах системийн ус, 59 м³ нь техникийн болон унд ахуйн хангамжийн системд ашиглана.

УЦС-ыг барьж дуусах 5 жилийн хугацаанд унд-ахуйд 9600.0 м³/жил ус хэрэглэх ба харин УЦС-ын ашиглалтын үеийн унд-ахуйн ус хэрэглээ нь 3240 м³/хон байна.

2.15 Химийн бодисын хэрэглээ

Төслийн ТЭЗҮ-д барилгын ажлын үед болон ашиглалтын үед хэрэглэх химийн бодис, түүний хэрэглээ зориулалтын талаар тусгаагүй байна.

Барилгын ажлын үед туннелийн ухлагын үед тэсрэх бодис хэрэглэнэ. Тэсэлгээнд хэрэглэгддэг химийн бодисуудаас эмульсийн тэсрэх бодисыг ашиглах боломжтой. Эмульсийн тэсрэх бодис нь аммиакийн шүү, парафин, дизель түлш, ус, карбамид, натрийн шүү, эмульгатор зэрэг усан болон тосон фазын уусмалууд болох химийн нэгдлүүдийн найрлагатай бөгөөд ил далд уурхай болон барилгын тэсэлгээний ажилд өргөнөөр хэрэглэгддэг, хүний эрүүл мэнд, байгаль орчинд ямар нэгэн хор нөлөөгүй тэсрэх бодис юм. Туннелийн ухлагаас гарах 195 мянган тонн чулуулгийг тэслэхэд 97.5 мянган тонн тэсрэх бодис хэрэглэхээр байна.

2.16 Цахилгаан болон дулаан хангамж, агаар сэлгэлт

Цахилгаан хангамж. УЦС-ын барилгын ажлын ЦЭХ-ний хэрэглээг Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын төвөөс 35 кВ-ын ЦДАШ-аар татаж хангана. Энэ үе шатанд шаардагдах ЦЭХ-ий хамгийн их хэрэглээ нь урьдчилан тооцоолсноор 5000 кВт.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг Баруун бүсийн ЦЭХС-д 230 кВ-ын хоёр хэлхээ ЦДАШ-аар Мянгат дэд станцтай, 35 кВ-ын нэг хэлхээ ЦДАШ-аар Эрдэнэбүрэнгийн 35 кВ-ын дэд станцтай холбоно. УЦС-ын үндсэн барилга доторх цахилгаан эрчим хүчний хэрэглээний ачаалал нэг дор төвлөрсөн байх бөгөөд 0.4 кВ-ын хүчдэлтэй байна. Үндсэн боомтын байгууламж станцын барилгаас 6.0 км хол учраас 0.4 кВ-ын шугам сүлжээний хамрах хүрээнээс гарсан байх тул 10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам татаж 10/0.4 кВ-ын дэд станц барьж боомтын орчимд байх хэрэглэгчдийг хангана.

Дулаан хангамж, агаар сэлгэлт. Барилгын ажлын үе шатанд барилгын гүйцэтгэгч компаниуд нь ажилчдын тосгоны дулаан хангамжийг ЦЭХ ашиглан өөрсдийн сонгосон хувилбаруудаар шийдвэрлэх боломжтой.

УЦС-ын ашиглалтын үед бага оврын 30 ш, дунд оврын 8 ш, өндөр температурын 40 ш халаагуур, 4 ш агаар үлээгч, 15 ш агааржуулах салхилууртай, харин засварын цех нь ердийн ба механик агааржуулагчтай байна.

2.17 Хог хаягдал

Эрдэнэбүрэнгийн УЦС төслийг хэрэгжүүлэх үед гарах хог хаягдал нь төсөл хэрэгжих үе шатуудад харилцан адилгүй байна. Үүнд:

Бэлтгэл ажлын үе шат: Энд багийн төв болон Ховд голын дагуу амьдардаг малчдыг усанд автах талбайгаас нүүлгэн шилжүүлэх, төслийн талбайн хэсгийн мод бут сөөгөөс чөлөөлөх, төслийн талбай ба түүний ойр орчимд байрших археологийн олдворуудыг авран хамгаалах малтлага хийх үед гарах хог хаягдлууд хамаарна.

Нүүлгэн шилжүүлэх, хог хаягдлын цэвэрлэгээний дараа ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээ авсны дараа дарж булан тэгшилж нягтруулах арга хэмжээ авна.

Барилгын ажлын үе шат: УЦС-ын барилгын ажил нь олон жил үргэлжлэх том хэмжээний бүтээн байгуулалт тул цемент, бетон, асфальт бетон, түгээмэл олдоцтой барилгын материал (элс, хайрга, чулуу, шавар)-ын үлдэгдэл хаягдал барилгын материалын сав баглаа боодол, ШТМ-ын сав, ашигласан тос, тосолгооны материал, машин техникийн засварын үеийн хог хаягдал гэх мэт нилээд их хэмжээний хог хаягдал гарах болно.

Мөн энэ үе шатанд талбайд 1000 орчим хүн ажиллах тул ажилчдын ахуйн хэрэглээнээс хоногт 500 кг орчим хатуу хог хаягдал, ойролцоогоор 34 м³/хон шингэн хаягдал гарахаар байна.

УЦС-ын ашиглалтын үе шат: УЦС-ын ашиглалтын үед ашиглалтын хугацаа дууссан сэлбэг материал, сав баглаа боодол, засварын үеийн хаягдал, ашигласан тос тосолгооны материал зэрэг хатуу, шингэн хаягдал гарна. Мөн ажилчдын ахуйн хэрэглээнээс 12.8 тн/жил хатуу хог хаягдал, 2.4 м³/хон шингэн хаягдал гарна.

Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ашиглах боломжгүй хэсгийг зөвшөөрөгдсөн хогийн цэг рүү зөөж зайлуулах ба харин гялгар уут, хуванцар, шил, төмөр материал зэргийг хаягдал боловсруулах үйлдвэрт нийлүүлж, цаас, модны хаягдлыг шатааж ашиглах боломжтой.

2.18 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Төслийн техник эдийн засгийн үндэслэлд тусгасны дагуу Эрдэнэбүрэнгийн УЦС байгуулахад тодорхой хэмжээний талбайд усан сан үүсгэхээр төлөвлөж байгаа бөгөөд 1325 метрийн өндөрлөгөөр (д.т.д) усны түвшин байна гэж тооцоолсон байна. Тиймээс голын эргийн дагуух 1325 м (д.т.д) өндөртэй газар нутаг усан санд бүрэн автах тул тухайн газар нутгийг нөлөөлөлд бүрэн өртсөн, усаар хучигдах нөлөөлөл нь зайлсхийх боломжгүй, мөн нөхөн сэргээх боломжгүй тул дүйцүүлэх хамгаалагдах талбай байх болно гэж үзсэн.

“Эрдэнэбүрэнгийн УЦС” төслийн үлдэгдэл нөлөөллийн талбай нь 9871.1 га болж байна. Энэхүү талбайг төслийн шууд нөлөөллийн талбай гэж үзнэ. Нөлөөлөл орон зайд буурах функц ашиглан тооцоолбол “Эрдэнэбүрэнгийн УЦС” төслийн нөлөөлөл их 10,200.78 га, дунд 64.34 га, бага 601.61 га бөгөөд нийт 10,866.73 га болж байна.

Орон зайн болон цаг хугацааны нөлөөллийг тооцоолсоноор дүйцүүлэн хамгаалах нийт талбайн хэмжээ нь 97,843.18 га болж байна.

Хээрийн судалгааны үндсэн дээр Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт орших Цамбагарав уулын БЦГ-ын хил залгаа 23,488.5 га газар болон Увс аймгийн Өмнөговь сумын хувьд Алтан Хөхүйн Байгалийн нөөц газрын 22,982.7 га газрыг сонгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээг оноотүнэлгээний аргаар тооцон доорх хүснэгтэд үзүүлээ (БОННУ тайланд тусгасанаар).

Хүснэгт 1. Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөллийн үнэлгээ

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт							
Гадаргын усны чанарын өөрчлөлт	2	2	1	2	7	28	Бага
Ургамлын бүтцийн өөрчлөлт	2	2	2	4	10	40	Дунд
Хөрсний элэгдэл, эвдрэл	6	3	3	4	16	64	Дунд
Геологийн тогтоцын өөрчлөлт	2	2	1	2	7	28	Бага
Зэрлэг ан амьтадын орон зайн өөрчлөлт	2	2	2	3	9	36	Дунд
Агаарын орчин /бохирдол/	4	2	2	3	11	44	Дунд
Газар доорх усны нөөц	2	2	1	2	7	28	Бага
Дундаж						38.3	Дунд
Байгалийн нөөцийн ашиглалт							
Газрын гадаргын нөөц	3	2	2	2	9	36	Дунд
Бэлчээр, хадлангийн байдал	4	2	2	3	11	44	Дунд
Эрдэс түүхий эдийн нөөц	2	2	1	2	7	28	Бага
Дундаж						34.7	Дунд
Байгаль орчны өөрчлөлт							
Ундны усны чанар, хэмжээ	2	2	1	2	7	28	Бага
Хөрсний бохирдол	3	2	2	3	10	40	Дунд
Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	4	2	2	3	11	44	Дунд
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	2	2	1	2	7	28	Бага
Ландшафтын хэлбэр өнгө төрх өөрчлөгдөх	2	2	1	2	7	28	Бага
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл	+						+
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөл	+						+
Дундаж						33.6	Дунд
Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл							
Тусгайхамгаалалттайбайгалийн цогцолборт газарт нөлөөлөл	2	2	1	2	7	28	Бага
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөл	4	2	2	4	12	48	Дунд
Археологи,палентлогийнолдворт нөлөөлөл	4	2	2	4	12	48	Дунд
Дундаж						41.3	Дунд
Бусад нөлөөлөл							
Автотээвэрлэлтээсшалтгааланхөрс эвдрэх	4	2	2	4	12	48	Дунд
Ахуйн хог хаягдлын цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, хортон шавьж үржих	2	2	1	2	7	28	Бага
Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг гамшиг гарах	2	2	1	3	8	32	Дунд
Дундаж						36.0	Дунд
Ерөнхий дундаж						36.78	Дунд

Тайлбар: нөлөөлөл байхгүй бол (0) тэмдэглэгээг хийсэн болно.

- ✓ Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт. Хүснэгт 1-ээс үзэхэд байгалийн төрөл зүйлүүдээс ЦДАШ-ын болон УЦС-ын барилга байгууламжуудын буурийн ухлага малталт, ерөмдлөг-тэсэлгээ, материал олборлох, чулуу бутлах, барилгын материалыг ачих болон буулгах, барилга барих явцад гарах хөрсний элэгдэл, эвдрэл, агаар орчны бохирдол, ургамлын бүтцийн өөрчлөлт, амьтны амьдрах орчны өөрчлөлтөд зэрэгт

үзүүлэх нөлөөллийн зэрэг “дунд”, харин бусад төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн зэрэг “бага” байна.

- ✓ Байгалийн нөөцийн ашиглалт. УЦС-ын барилга байгууламжийн бэлтгэл ажлыг хангах болон барилгын ажлыг гүйцэтгэх, усан санг дүүргэх явцад газар, түүний дотор бэлчээрийн болон байгалийн хадлангийн нилээд талбай хамрах тул тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл “дунд” зэрэг, харин эрдэс түүхий эдийн нөөцөд нөлөөлөл сөрөг нөлөөлөл “бага” байхаар гарч байна.
- ✓ Байгаль орчны өөрчлөлт. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын бэлтгэл болон барилга байгууламжуудыг барих үндсэн үйл ажиллагааны явцад материал, тоног төхөөрөмжийн тээвэрлэх болон барилгын бүтээн байгуулалтын үед гарах тоос, тоосонцроос бохирдох хөрсний бохирдол, агаар орчны физик бохирдол “дунд” зэрэг, харин усны чанар, хэмжээ, байгалийн үзэсгэлэнт төрх болон ландшафтын хэлбэр, өнгө төрхөд үзүүлэх нөлөөлөл “бага” байна.
- ✓ Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл. Байгалийн цогцолборт газрын хилийн цэсийн гадна УЦС-ын барилга байгууламж, усан сан байгуулагдах учир түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага”, харин төсөл хэрэгжих талбарт олон тооны түүх соёлын дурсгалт зүйл, археологийн олдворууд илэрсэн тул тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл “дунд” зэрэг байхаар байна.
- ✓ Бусад нөлөөлөл. Бэлтгэл болон барилгын ажлын үеийн авто тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх болон байгалийн давагдашгүй хүчин зүйл /хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга/-ийн нөлөөллийн зэрэг “дунд”, ахуйн хог хаягдлын ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих нөлөөллийн зэрэг “бага” байхаар байна.

3.1 Төслийн болзошгүй нөлөөллийг Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга (Checklist)-аар тооцсон үнэлгээ

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн байгаль орчны төлөв байдалд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, түүний үргэлжлэх хугацаа, давтагдалт болон эрчмийг тодруулах үнэлгээг дараах хүснэгтэд үзүүлэв. Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг 6 үндсэн бүлэгт хуваан авч үзэв. Нөлөөллийн байдлыг үнэлэхдээ сөрөг (-), эерэг (+), нөлөөлөлгүй (0) гэсэн 3 үзүүлэлтээр шинжээчдийн саналыг харгалзан хүснэгтэд харуулсан болно.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн жагсаалт

дд	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөллийн хэлбэр			Үргэлжлэх хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага	Дунд зэрэг	Хүчтэй
Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Гадаргын усны нөөц	+				x		x		x	
2	Газрын доорхи усны нөөц	+				x		x		x	
3	Ойн нөөц	-				x		x	x		
4	Хөрсний эвдрэл	-			x			x		x	
5	Геологийн тогтоц	-			x			x	x		
6	Зэрлэг амьтдын орон зай	-				x		x	x		
7	Уур амьсгал		+			x		x	x		
Байгаль орчны аюул, осол											

8	Хор аюултай бодисын ашиглалт, хадгалалт холбоотой буюу түүний ашиглалтаас шалтгаалах аюул осол	-			x			x	x		
9	Байгаль орчны аюул гамшиг нэмэгдэх, магадлал нь ихсэх шалтгаан бий болох	-				x		x	x		
10	Тухайн орон нутгийн байршил нь аюулт үзэгдлийн нөлөөлөлд эмзэг байх	-				x		x	x		
Байгалийн нөөц, ашиглалт											
11	Гадаргын нөөц баялаг	-				x		x	x		
12	Бэлчээрийн байдал	-				x		x	x		
13	Газар тариалан	+									
14	Эрдэс түүхий эдийн нөөц	-			x			x	x		
15	Эрчим хүчний нөөц	+				x		x			x
Байгаль орчны өөрчлөлт											
16	Усны чанар, хэмжээ			+		x		x	x		
17	Урсгал усны хэрэгцээ	+				x		x	x		
18	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх	-			x			x	x		
19	Агаарын бохирдол	-			x			x	x		
20	Хөрсний элэгдэл, бохирдол	-			x			x		x	
21	Дуу чимээний нөлөө	-			x			x	x		
Байгалийн үзэсгэлэнт нутаг, амралт, жуулчлал											
22	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-			x			x	x		
23	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	+				x		x	x		
24	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	-				x		x	x		
25	Аялал жуулчлал, амрах нөхцөлд нөлөөлөх			+		x		x		x	
Түүхийн дурсгалт зүйл, соёлын өв, археологи палеонтологийн олдвор											
26	Түүхийн дурсгалт зүйлд нөлөөлөх	-			x			x	x		
27	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	-			x			x	x		
Дүн		20	6	1	11	15	-	26	20	5	1
Сөрөг нөлөөлөл											
Эерэг нөлөөлөл											

Хүснэгтээс үзэхэд байгаль орчинд үзүүлэх 26 болзошгүй нөлөөлөл байгаагаас шууд нөлөөлөл 19, шууд бус нь 6, өөрөө зохицуулагдах нөлөөлөл 1 байна. Үүний 18 нь сөрөг, 8 нь эерэг нөлөөлөл байгаагаас УЦС-ыг барих хугацаанд үйлчлэх богино хугацааны 10 сөрөг нөлөөлөл, урт хугацааны нөлөөлөл 16 байна. Мөн нийт нөлөөлөл нь буцалтгүй нөлөөлөл байгаа ба түүний 77% нь бага, 19.2% нь дунд зэрэг, 3.8%-д нь хүчтэй нөлөөлөхөөр байна.

- ✓ *Шууд нөлөөлөл* – Болзошгүй нөлөөллийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамрагдаж байгаа ба үүнд барилга байгууламжуудыг барих үед хөрс, хучаас хөрсийг хуулах, газрын хурдас руу ухлага хийж зарим газрын геологийн тогтоцыг эрс өөрчлөх, усан сан байгуулснаар газрын доорх болон гадаргын усны нөөцөд олон жилийн турш өөрчлөлт оруулах, эрдэс түүхий эдийн /элс хайрга, ус/ нөөц баялгийг авч ашиглан түүний нөөцийг багасгах, газар ашиглалттай холбоотой /хөрсний эвдрэл ба элэгдэл гарах, ихээхэн хэмжээний талбайг усанд автуулснаас бэлчээрийн болон хадлангийн талбай хомсдох г.м/ зэргээс шалтгаалж экологийн тухайн орчны экосистемд нөлөөлөх, байгалийн тэнцвэрт нөлөөлөх сөрөг муу тал үзүүлж байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлснээр хиймэл нуур үүсч байгалийн үзэсгэлэнт төрхбайдал, ландшафтад эерэг өөрчлөлт гарахаар байна.
- ✓ *Шууд бус нөлөөлөл* – Байгаль орчны аюул осол, төсөл хэрэгжих нутагт ойр орших тусгай хамгаалалттай газарт нөлөөлөх, ус хэрэглээний асуудлаар, бусад газрын үйл ажиллагаанд нөлөөлөх зэрэг 5 сөрөг нөлөөлөл байж болохоос гадна хиймэл нуур

үүссэнээртэр орчинд нь бичил уур амьсгалын таатай нөхцөл, аялал жуулчлал, амрах нөхцлийг бүрдүүлэх эерэг нөлөөлөл бий болж болох юм.

- ✓ *Богино хугацааны нөлөөлөл* – Бүтээн байгуулалтын үе шатны хугацаа нь 5 хүртэл жил байгаа тул богино хугацааны нөлөөлөл 11 байгаа ба тэдгээр нь бүгд сөрөг нөлөөлөлд хамаарна. Үүнд хөрсний эвдрэл, элэгдэл ба геологийн тогтоцын өөрчлөлт, агаарын тоосжилт ба бохирдол, ойн усанд авталт, тэсрэх бодисын болон түлш шатахууны хадгалалташиглалттай холбоотой гарч болох осол ба усны түр зуурын бохирдол, түүх соёлындурсгалт зүйлд үзүүлэх нөлөөлөл зэрэг хамаарч байна.
- ✓ *Урт хугацааны нөлөөлөл* – Бэлтгэл болон барилгын ажил цөөн /5 хүртэл/ жилд үргэлжлэх боловч УЦС-ын ашиглалт нь урт удаан хугацаанд үргэлжлэх тул байгаль орчинднөлөөлөл 16 нөлөөлөл нь удаан хугацаанд үргэлжлэхээр байна. Эдгээрийн 8 нь эерэг, 8 ньсөрөг нөлөөлөл байна. Эерэг нөлөөлөлд: гадаргын ба газрын доорх усны нөөц нэмэгдэх, бичил уур амьсгал, эрчим хүчний нөөц нэмэгдэх, усны чанар хэмжээ, урсгал усны хэрэгцээ,нуур үүсч ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх, аялал жуулчлал нэмэгдэх зэрэг байна. Сөрөг нөлөөлөлд нуур үүссэнээр амьтдын амьдрах орон зай багасах, малын бэлчээр, хадлангийн талбай багасах, ойн нөөц багасах, байршлын хувьд аюулт үзэгдлийн нөлөөлөлд эмзэг байх, байгаль орчны аюул гамшиг нэмэгдэх, магадлал нь ихсэх шалтгаанбий болох зэрэг хамаарч байна.
- ✓ *Нөлөөллийн давталт* – Нийт нөлөөлөл нь буцалтгүйгээр нөлөөлөлж байгаа ба үүнээс 18 сөрөг, 8 эерэг нөлөөлөлд хамаарч байна.
- ✓ *Нөлөөллийн эрчим* – Нийт нөлөөллийн 20 нь бага, 5 нь дунд зэрэг, 1 нь хүчтэй эрчимтэй байна. Дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөлд гадаргын болон газрын доорхи усны нөөцийн өөрчлөлт, хөрсний эвдрэл ба элэгдэл, бохирдол зэрэг нөлөөллийг хамааруулж байгаа болно.

Газрын гадарга, хөрсний элэгдэл, эвдрэл ба ургамалан нөмрөг, гадаргын усанд голлох нөлөөллийг /тус УЦС 2025 онд баригдаж дуусах/ авч үзсэн байна. Гэхдээ бүтээн байгуулалтын үед гарсан хөрсний элэгдэл, эвдрэлийн боломжтой хэсгийг нөхөн сэргээх талаар авах арга хэмжээг тусад нь авч үзэхээс гадна Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тодорхой тусгах нь зүйтэй гэж үзсэн байна.

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр гаргасан байгаль хамгаалах, гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, цаашлаад арилгахаар санал болгож буй арга хэмжээний талаархи зөвлөмжийг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлж ажиллахаар тусгасан байна. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- ✓ Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлагаа мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- ✓ Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор бууруулж, байгаль орчныг хамгаалж, байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах, сайжруулах зорилтыг хангах үүднээс тэнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;
- ✓ Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага нэг бүрт мөрдөх технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- ✓ Улс, аймаг, сумын холбогдох хяналтын байгууллага, улсын хяналтын байцаагч, баг хэсгийн иргэд, айл өрх, аж ахуйн нэгжүүд болон сонирхогч хүмүүстэй төслийн үйл ажиллагаа ба түүний онцлог, байгаль хамгааллын талаар зохих ёсоор зөвлөлдөж саналыг нь авч, хамтран ажиллах;
- ✓ Болзошгүй аваар ослын үед авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг цаг үеийн хэрэгцээ шаардлагын дагуу байнга шинэчлэх шаардлагатай бөгөөд энэ нь аливаа нэгэн ослын үед (зөрчлийн тухай мэдэгдэж тайлагнах, шалгах дэг журам, урьдчилан сэргийлэх ба залруулах арга хэмжээ) мөрдөгдөхөөр байх;
- ✓ УЦС-ын ашиглалт, түүний хэт ирээдүйн явц байдлаас байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нарийвчлан тусгасан байх;
- ✓ УЦС-ын аюулгүйн зон-хамгаалалтын бүсийн дэг журам, түүнд учирч болох газар ашиглалттай холбоотой бэрхшээлүүд, байгалийн нөхцөл, ойр орчмын суурьшил, бэлчээр ашиглалтаас төслийн үйл ажиллагаанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүний хэтийн төлөв;
- ✓ Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулсан зааварчилгаа өгөх;
- ✓ Байгаль орчны менежментийн талаар БОННУ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;

Төслийн хэрэгжилтийн явцыг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлэн явуулахын тулд түүнийг хариуцсан байгаль орчны хэлтэс ажиллуулах, жил бүр Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох зөвлөмж аргачлал авч ажиллах, зарим цаг уурын харуулыг өргөтгөж өртөө болгох, шинээр цаг уурын, усны, чичирхийллийн харуулууд байгуулах, мөн хөрс-ургамал, гүний усны хяналтын цэгүүд тогтоож тохижуулах, суурин болон хөдөлгөөнт багаж төхөөрөмжүүдээр тогтмол хэмжилт явуулж байх талаар төлөвлөгөөнд

тусгасан болно. Иймд менежментийн төлөвлөгөө нь энэ төслийн салшгүй нэгхэсэг төдийгүй түүний хэвийн жигд ажиллагааг хангахад байгаль орчны талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь болж өгнө.

Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх зардлын төсөв: УЦС барих төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, ТЖБОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүс дэх оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөнд 2,912,991,300 төгрөгийг төлөвлөсөн.

УЦС-н төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн дүгнэлтийг шинэчлэн тодруулж БОАЖЯ-ны ТНБД-д хүргүүлсэн 2022 оны 03 сарын 31-ний өдрийн №03/1637 албан тоотойр БОННУ тайлангийн шаардлагын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг дэмжсэн байна. Тус албан бичгийн хүрээнд Монгол улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 05 сарын 20-ны өдрийн А/108 тоот “Зардлын төсвийг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар 2,036,936,300 төгрөг, 2022 оны 11 сарын 10-ны өдрийн А/235 тоот “Зардлын төсвийг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар БОМТ-ний зарим зардлуудыг шилжүүлж баталсаны хүрээнд тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлж ажиллалаа.

Одоогийн байдлаар төлөвлөсөн хэрэгжилт Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын иргэд, Увс аймгийн Улиаст багийн иргэдийг нөлөөллийн бүсээс нүүлгэх ажил удаашралтай, “Эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээ”, “Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй иргэдэд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай” гэрээний явц 80%-ийн биелэлттэй байна.

5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

дд	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн/
1	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 51 өрх, Увс аймгийн Өмнөговь сумын 40 өрх	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	д.т.д 1305 м, 1310 м өндөрт байрлах айлууд	91 айл өрх	1,320,511,900.0₮	Хэрэгжиж байгаа - Айл өрхүүдтэй гэрээ байгуулах, нөхөн олговор олгох эрхийг аймгуудын ЗДТГ-т шилжүүлэх ажил хийгдсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 80%-тай хэрэгжиж байна.
2	Шинээр барих Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төв	Зураг төсөл боловсруулах ажил	Нөлөөллийн бүс	Багийн төв	236,276,700.0₮	Бүрэн хэрэгжсэн - Гэрээ хийгдсэн. Зураг төслийн ажил боловсруулагдаж байгаа бөгөөд тайлангийн 5.2-т дэлгэрэнгүй тусгав.
3	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн шинэ суурьшилын бүс, 160 хүүхдийн сургууль, 50 хүүхдийн цэцэрлэг	Ерөнхий төлөвлөгөө болон барилгын зураг төсөл боловсруулах ажил	Нөлөөллийн бүс	Багийн төвийн сургууль, цэцэрлэг	189,691,700.0₮	Бүрэн хэрэгжсэн - Гэрээ хийгдсэн. Зураг төслийн ажил боловсруулагдаж байгаа бөгөөд тайлангийн 5.3-т дэлгэрэнгүй тусгав.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний бэлтгэл ажил	ХАА, Байгаль орчны хүрээнд ТББ-тай хамтран ажиллах	Нөлөөллийн бүс	-	70,000,000.0₮	Тайлбарыг 5.4-т тусгав.
5	Нөлөөлөлд өртөж буй айл өрхийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын гэрээг хуулийн хүрээнд шийдвэрлэх	Хуулийн фирмтэй хамтран ажиллах	Нөлөөллийн бүс	-	10,000,000.0₮	Бүрэн хэрэгжсэн - Тайлангийн 5.5-т дэлгэрэнгүй тусгав. /Гэрээг хавсралтаар тусгав/
6	Нөлөөлөлд өртөж буй айл өрх, түүх соёлын өвийн нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэрэгжилт явцыг дүрсэн хэлбэрээр танилцуулах	Программ хангамж боловсруулах	Нөлөөллийн бүс	-	11,000,000.0₮	Бүрэн хэрэгжсэн - Тайлангийн 5.6-т дэлгэрэнгүй тусгав.

5.1 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний хэрэгжилт

ТОМИЛОЛТ 1: Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажлыг БОННУ тайланд тусгагдсанаар Баяннуур сумын 145 өрх, Өмнөговь сумын 125 өрх буюу нийт 270 өрхийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд 91 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, нөхөн олговор олгох ажлын хэрэгжилтийн бэлтгэлийг хангах, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас төслийн усан сан бүрэлдэх талбайд оршин сууж байгаа нийт 270 айл өрхийн 1241 иргэн нэг бүрт нэг удаагийн нөхөн олговор олгох шийдвэр хэлэлцүүлгийн шатандаа явж байгаатай холбогдуулан төслийн БОННУ-ний тайланд тусгагдсан дээрх айл өрх, иргэдийн бүртгэл, тоо мэдээллийг тулган баримтжуулах зорилгоор Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст баг, Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд 2022 оны 05 сарын 22-ны өдрөөс 2022 оны 06 сарын 09-ний өдөр хүртэл албан томилолтоор ажилласан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

- ✓ ЭБУЦС ТХН-ийн баг: УББ-ын инженер Б.Болд, цахилгааны инженер С. Баатарзул, барилгын инженер Э.Наранмандах, талбайн инженер Э.Төгөлдөр, Санхүүгийн ажилтан Б. Отгон, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Г.Батцэцэг, техникийн ажилтан Т.Амарсайхан, жолооч Б. Жамбал.
- ✓ Увс аймгийн ажлын хэсэг: Увс аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Баяраа, Өмнөговь сумын сум дундын Цагдаагийн хэсгийн дарга, дэд хурандаа Н.Түвшинбаяр, Аймгийн улсын бүртгэлийн газрын Улсын бүртгэгч Ш.Батсанаа, Аймгийн ГХБХБГ-ын суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Нямжав, Өмнөговь сумын Улсын бүртгэгч Н.Гантуяа, Увс аймгийн ЗДТГ-ын жолооч Д.Төгөлдөр.
- ✓ Баян-Өлгий аймгийн ажлын хэсэг: Баян-Өлгий аймгийн Засаг даргын орлогч Х.Арман, тагнуулын газрын ажилтан Д.Жаргал, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Д.Аманбек, Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Мониторинг хариуцсан мэргэжилтэн Б.Аманбек, Баяннуур сумын хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч Х.Серик, Баяннуур сумын иргэний бүртгэлийн улсын бүртгэгч Д.Тойжан, Баяннуур сумын газрын даамал Ц.Алмабек, Баяннуур сумын 1. 2. 4, 5 дугаар багийн Засаг дарга нар, Баяннуур сумын Засаг даргын Тамгийн газрын дарга М.Зангар.

Тус ажлын батлагдсан удирдамжын дагуу айл өрхийн бүртгэлийн хуудас, иргэний бүртгэлийн хуудсыг БОННУ-ний тайлангийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахдаа айл өрх нэг бүрээр орж, холбогдох бүх баримт бичгийг үндэслэн бүртгэлжүүлсэн.

- ✓ Айл өрхийн бүртгэлийн хувьд: БОННУ-ний тайланд тусгагдсан мэдээлэл бүхий айл өрхийн бүртгэлийн хуудсыг бөглөхдөө өрхийн гэр, сууц, өвөлжөө, хаваржаа, намаржааны координатыг газар дээр нь хэмжиж тэмдэглэх, бодит зургийг авч баримтжуулах, аливаа Улсын бүртгэлийн гэрчилгээний зургийг авч баримтжуулах, бүртгэлийн хуудсыг гэрийн эздэд танилцуулан гарын үсгээр баталгаажуулан нэг хувийг өрхөд, нэг хувийг төсөлд авсан.
- ✓ Иргэний бүртгэлийн хувьд: БОННУ-ний тайлан дахь өрхийн тоог тулгаж тухайн өрхөд бүртгэлтэй иргэдийн мэдээллийг харьяалах орон нутгийн Улсын бүртгэгчийн мэдээлэлтэй тулган тэмдэглэгээ хийлгэж иргэн бүрийн баримт бичгийн зургийг авч баримтжуулсан.

Тус ажлын хэсгүүд Увс болон Баян-Өлгий аймгуудын 270 өрхийн 1241 иргэний бүртгэл хийх зорилготой байсан ч 268 өрхийн 1253 иргэн хамрагдсанаас 230 өрхийн 1002 иргэний бүртгэлийг хийж, 14 өрхийн 71 иргэн тодорхой шалтгаанаар эзэнгүй, 24 өрхийн 112 иргэн бүртгэл хийлгэхээс татгалзсан байна.

Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст баг

Төслийн нэгжийн баг, Увс аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/276 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хамтран 2022 оны 5 дугаар сарын 23-наас 28-ны хооронд төслийн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багт ажилласан. Томилогдсон ажлын хэсэг төслийн нэгжийн багтай нягт хамтарч ажилласан.



Бүртгэлд нийт 125 айл өрхийн 509 иргэн хамрагдахаас нөлөөллийн бүсэд оршин суудаг боловч БОННУ-ийн тайланд тусгагдаагүй 4 өрхийн 13 иргэний бүртгэлийг хамруулсан. Тодруулбал:

- ✓ Бүртгэлд хамрагдсан 129 өрхийн 496 иргэн.
- ✓ Бүртгэлээ баталгаажуулсан 95 өрхийн 331 иргэн.
- ✓ Гадаад, дотоодод зорчсон, эмчилгээнд явсан, бүртгэл хийлгэх хууль эрхзүйн чадамжтай иргэн байгаагүй болон бичиг баримтгүй зэрэг шалтгааны улмаас 10 өрхийн 48 иргэн бүртгэл баталгаажуагүй.
- ✓ Бүртгэлээ хийлгэхээс татгалзсан 24 өрхийн 112 иргэн байна.



Улиаст багийн хувьд айл өрхүүдээр орж төслийн ажлын явц, ач холбогдол, үр өгөөж, усан цахилгаан станц барих зайлшгүй шалтгааны талаар таниулсны дараа өрхийн болон иргэний бүртгэлийг хийж ажилласан. Өвөл, хавар хур тунадас бага байснаас хөрсний чийг хангамж муу, хавар хуурайшилт ихтэй, зуншлага тааруу байгаагаас айлууд уулын ар шил рүү нүүж нутаг сэлгэсэн, зарим айлын байршил тодорхойгүй байсан нь бүртгэлийн ажилд хүндрэл учруулсан.



Иргэний цахим үнэмлэхэнд шилжилт хөдөлгөөний мэдээлэл байхгүйн улмаас харьяалал тогтооход хүндрэл учирч байна. Гадаад, дотоодод зорчсон, эмчилгээнд явсан шалтгаанаар эзгүй байсан, бүртгэл хийлгэх хууль эрхзүйн чадамжтай иргэн байгаагүй болон бичиг баримтгүй /Казакстан Улсын иргэн/ зэрэг шалтгааны улмаас 4 өрхийн 23 иргэн бүртгэл баталгаажуагүй.

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт, Шар цэхээ, Баяннуур баг

Ажлын хэсэг БОННУ-д тусгагдсан Баяннуур сумын нөлөөлөлд өртөж буй Цэцэгт, Шар цэхээ, Баяннуур багуудын 145 айл өрхөөр нэг бүрчлэн орж иргэний бүртгэл, байршлын координатыг тулган шалгаж, фото зургаар баталгаажуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.




Баян-Өлгий аймагт байгуулагдсан ажлын хэсгээс аймгийн Улсын бүртгэлийн тасгийн дарга Д.Аманбек, Баяннуур сумын бүртгэгч Д.Тойжан нар баталсан төлөвлөгөөний дагуу хуваарьт ажлыг амжилттай гүйцэтгэсэн.

Төсөл хэрэгжүүлэх нэгж, Баян-Өлгий аймгийн Засаг дарга Д.Бауыржаны 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/353 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг хамтран 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хуралдан Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд ажиллах томилолтын удирдамж, төлөвлөгөө боловсруулан протокол хөтөлж айл өрхүүдийн байршлаас хамааран хуваарь гарган аймгаас томилогдсон улсын бүртгэгч, ажлын хэсгийн гишүүд, төслийн нэгжийн багууд хүн хүчээ хуваарилан 2 баг болж ажиллахаар зохион байгуулан ажилласан.



Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ард иргэдийн хувьд иргэний бүртгэл мэдээллийн судалгааг эсэргүүцэх хандлага харьцангуй бага ажиглагдсан. Харин орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай нэгдэн хэлний давуу талаа ашиглан иргэний бүртгэлээ илүү хүнээр хийх оролдлого их гаргаж байсан. БОННУ-ний тайланд давхар бүртгэгдсэн, гэрийн эзэн нас барсан тул эхнэр буюу ээж нь хүүхдийнхээ асрамжинд ирсэн, Баян-Өлгий аймгийн хувьд хүүхдүүдээ эмээ, өвөөд нь үрчлүүлдэг тохиолдол их ажиглагдсан бөгөөд бидний хувьд иргэний үнэмлэхэд бичигдсэн хаяг, овог нэрийг баримтлан ажилласан.



“ЭРДИЭВЭРЭГНИЙ УСАН ЦАХИМГААН СТАНЦ” ТӨСӨЛ
Аял, өрхийн бүртгэлийн хуудас

2022 оны 6 сарын 3 ны 10-ий өдөр

№	Өрхийн тэргүүн (овог, нэр)	Ажлын байрны тусгай зөвшөөрлийн үйлчилгээний байр	Хэргийн огноос өмд суурилуулагдсан байгаа	Ажил эрхлэлт тусгай зөвшөөрлийн үйлчилгээний байр	Газрын гэрэмжлэлт	Малын тоо	Өвөлжөө, хаваргаа болон бусад зөв хөрөнгө	Ажлуулгын байрныг координат
138	Радхалын сэвсгэр Мөнх Радхалын Баярцог	✓	✓	✓	0304001-1999.02.1-6	1-4, №20, 1322-100, №424	10x10 м модон байшин (2004 онд барьсан), 4.хавт 8.0модон байшин (2018 онд барьсан), 2.5x3.5 м модон хайрбар, модон хайрбар, барилгын, хаваргааны талбай (23 кв), талбайнгийн талбай (2.8 кв), жингийн мод, хуучирсан талбай (2.8 кв) тусгай.	91°13'55.07" 48°35'15.97"

2. Өрхийн бүртгэл

Урхай овог	Овог	Нэр	Нас	Регистрийн дугаар	Хамт
Сарбас	Радхалын	Бидурман	58	БВ4000711	Эвэн-Огтой ахиад: Баяннуур сум, 4-р баг, Улаа, 10000.

3. Намалт мэдээлэл

Аял бүлгээс 100 кг зүүрэг, дэвсгэр (Өрхийн тэргүүн 2022.01.24-нд нас барсан), 200 кг жингийн мод, 40 кг жингийн мод, 100 кг жингийн мод, 100 кг жингийн мод, 100 кг жингийн мод.

Баталгаажуулсан:

Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн ажилтан: 1. А. Доржиев, 2. Б. Доржиев
ТХН-ийн төлөөлөгч: 1. Б. Доржиев, 2. Б. Доржиев

Өрхийн тэргүүн: 1. Б. Доржиев
Утасны дугаар: 3066.2.428

03.06.2022 18:20

Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолын хавсралт “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-ын 4.4-т Иргэний өмчилж байгаа газарт олгох нөхөх олговорт Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37.1-д заасны дагуу дараах зүйлийг хамруулан тооцно.

4.8. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор эргүүлэн авах тохиолдолд олгох нөхөх олговорт Газрын тухай хуулийн 43.2-т заасны дагуу дараах зүйлийг хамруулан тооцно гэж заасны дагуу газар өмчлөлийн буюу газар эзэмшлийн гэрчилгээтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авна гэсэн хуулийн зохицуулалттай. Баян-

Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт, Баяннуур, Шар цэхээ багт нөлөөллөлд өртөж буй иргэдийн хувьд газар өмчлөлийн гэрчилгээтэй айл байхгүй, газар эзэмшлийн гэрчилгээтэй цөөн байна.



Баян-Өлгий аймгийн нөлөөллийн бүсэд амьдрах нийт 139 айл, 736 иргэн нэг бүрчлэн орж иргэний бүртгэл, байршлын координатыг тулган шалгаж, фото зургаар баталгаажуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Нийт 4 айлын бүртгэл баталгаажаагүй байна. Үүнд: Баянбай Ерболат /ам бүл 4/ - бүртгэл баталгаажаагүй, Шошай Хайрат /ам бүл 6/ - бичиг баримт байхгүй, Хуан Манархан /ам бүл 6/ - Ховд аймагт эмчилгээнд явсан. Тус айлуудын координат эд хөрөнгийн баталгаажуулалт хийгдсэн. Камелхан Нурдаулет /ам бүл 7/ - координат эд хөрөнгийн баталгаажуулалт хийгдсэн, аймгаас ирэх ёстой байсан боловч ирээгүй.

БОННУ-ний тайлангийн бүртгэлд хамрагдаагүй зарим өрхүүд бүртгэлд хамруулах талаар өргөдөл ирсэн байна. Үүний шалтгаан тайлбарыг БОННУ-ний тайлан боловсруулсан “Нью гидро проект” ХХК, “Енко” ХХК-иар дамжуулан шийдвэрлэнэ.

Аймгаас байгуулагдсан ажлын хэсэг, ТХН-ийн хамтарсан нэгдсэн хурлаар: Бүртгэлд нийт БОННУ-д туссан 145 айл өрхийн 732 иргэн хамрагдахаас

- ✓ Бүртгэлд хамрагдсан 139 өрхийн 736 иргэн,
- ✓ Бүртгэлд хамрагдахаас татгалзсан 0 өрхийн 0 иргэн



Гадаад, дотоодод зорчсон, эмчилгээнд явсан шалтгаанаар эзгүй байсан, бүртгэл хийлгэх хууль эрхзүйн чадамжтай иргэн байгаагүй болон бичиг баримтгүй, харъяалалгүй /Казакстан Улсын иргэн/ зэрэг шалтгааны улмаас 4 өрхийн 23 иргэн бүртгэл баталгаажаагүй боловч бүртгэлжүүлэлтийн ажил амжилтай хийгдсэн болно /Айл өрхийн судалгаа болон МУ Эрчим хүчний сайдын 2022 оны 12 сарын 06-ны өдрийн А/249 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалыг тайланд хавсаргав/.

ТОМИЛОЛТ 2: Эрдэнэбүрэнгийн УЦС баригдах болон усан сан үүсэх нутаг дэвсгэрт 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл Эрчим хүчний Сайд Б.Чойжилсүрэнгээр ахлуулсан баг Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сум, Улиас баг, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Цэцэгт багуудад албан томилолтоор ажиллав. Тус томилолт нь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн ажлын явцтай танилцаж нөлөөлөлд өртөж буй ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх; Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч нартай төслийн талбай дээр уулзалт хийж, боомт, станц баригдах газар, өрөмдлөгийн ажилтай танилцах зорилготой байв.

Томилолтын бүрэлдэхүүн:

Эрчим хүчний Сайд Б.Чойжилсүрэн, Сайдын зөвлөх Ш.Отгон-Эрдэнэ, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, СХОГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар, БТГ-ын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга Х.Бекболат, ЭБУЦС төслийн зохицуулагч Ч.Гантулга, төслийн ерөнхий инженер Ж.Лувсандандар, төслийн усны барилга байгууламжийн инженер Б.Болд, төслийн барилгын инженер Э.Наранмандах, төслийн талбайн инженер Э.Төгөлдөр, төслийн техникийн ажилтан Т.Амарсайхан, төслийн жолооч Б.Жамбал, “Нью Гидро Проект” ХХК-ийн захирал Ц.Сосорбарам нарийн бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд хийсэн уулзалт:

Сайдаар ахлуулсан томилолтын баг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Эрдэнэбүрэн, Мянгад сумдын иргэдтэй Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын соёлын төвийн зааланд уулзалт хийж төсөлтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж санал солилцов.



Уулзалтын үеэр иргэдээс тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Ховд аймгийн Засаг дарга Э.Болормаа, Эрдэнэбүрэн сумын Засаг дарга У.Цэрэнтогтох, Мянгад сумын Засаг дарга М.Баатар нар болон бусад холбогдох албан тушаалтнууд тухай бүр хариултыг өгөв.

Увс аймгийн Өмнөговь суманд хийсэн уулзалт:



Сайдаар ахлуулсан томилолтын баг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн иргэдтэй тус сумын соёлын төвд уулзалт хийж төсөлтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж санал солилцов.

Уулзалтын үеэр иргэдээс тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Увс аймгийн Засаг дарга Ч.Чимэд, Өмнөговь сумын Засаг дарга С.Өлзий, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Даваасүрэн болон холбогдох бусад хүмүүсээс тухай бүр хариултыг өгөв.

Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд хийсэн уулзалт:

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхээр ахлуулсан томилолтын баг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын иргэдтэй тус сумын соёлын төвд уулзалт хийж төсөлтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж санал солилцов.



Уулзалтын үеэр иргэдээс тавьсан асуултад Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын ХОХБТГ-ын дарга Х.Анар, Баяннуур сумын засаг дарга И.Дөрбетхан, Баяннуур сумын ИТХ-ын дарга М.Ахжол болон холбогдох хүмүүсээс тухай бүр хариултыг өгөв.

Төсөл хэрэгжих газар нутагт ажилласан тухай:

Сайдаар ахлуулсан томилолтын баг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр нуур үүсэх Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст баг, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн нутаг дэвсгэрт очиж газар нутгийн байдалтай танилцаж нуур үүсэх талбайн эргэлтийн цэгүүдэд очсон.



Мөн төслийн барилга угсралтын ажил явагдах Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумдын нутаг дэвсгэрт /Шижигтийн хавцалд/ гүйцэтгэгч байгууллагын суурин төлөөлөгчтэй уулзалт хийж өрөмдлөг судалгааны ажилтай танилцсан. Уулзалтын үеэр Ховд аймгийн засаг дарга Э.Болормаа болон бусад албан тушаалтнууд, Баян-Өлгий аймгийн байгаль орчны газрын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзсан байна.




Томиллолтоор усан сан үүсэх талбайд нөлөөлөлд өртөж буй ургамлан нөмрөг, шимт хөрсийг хамгаалахад төсөл боловсруулж, хэрэгжүүлэх, нөлөөлөлд өртөж буй мод бутыг нүүлгэн шилжүүлж, дүйцүүлэн хамгаалах, иргэдэд ахуй журмаар ашиглах эрхийг олгох, усалгааны системүүдийг барьж ашиглалтад оруулах, төслийн нөлөөлөлд өртөж буй иргэдийн зүгээс гарсан гомдлын дагуу эд хөрөнгийн үнэлгээ хийх зэрэг ажлуудыг дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.


5.2 Улиаст багийн төвийн зураг төслийн ажил боловсруулах

Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн зураг төсөл боловсруулах ажлын гэрээг “Аркосис” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ /Дугаар №202205054/-г байгуулсан. Увс аймгийн ЗДТГ-аас баталсан ажлын даалгаврын дагуу ажиллаж байна.


Улиаст багийн төвийн зураг төсөл боловсруулах ажлын гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг 12 сарын 13-ны өдөр байхаар тусгасан бөгөөд “Аркуосис” ХХК нь зураг төслийн ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна/Гэрээг хавсралтаар тусгав/.




Зураг 3. Улиаст багийн төвийн ерөнхий төлөвлөгөө




Зураг 4. Цэцэрлэгийн зохион байгуулалт



Зураг 5. Захирагчны байрны зохион байгуулалт



Зураг 6. Сургуулийн гадаад байгуулалт



Зураг 7. Үйлчилгээний төвийн зохион байгуулалт




Зураг 8. Харагдах байдал

5.3 Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл /160 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл, 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын иж бүрэн зураг төсөл/ боловсруулах ажлын гэрээг “Аркосис” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ /Дугаар №202205055/-г байгуулсан. Баян-Өлгий аймгийн ЗДТГазраас баталсан ажлын даалгаврын дагуу ажиллаж байна.

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл /160 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл, 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын иж бүрэн зураг төсөл/ боловсруулах ажлын гэрээнд ажил 12 сарын 13-ны өдөр байхаар тусгасан бөгөөд “Аркосис” ХХК нь зураг төслийн ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна/Гэрээг хавсралтаар тусгав/.



Зураг 9. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн ерөнхий төлөвлөгөө



Зураг 10. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн харагдах байдал

5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний бэлтгэл ажил

Эрчим хүчний яамнаас 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр зарласан “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн нөлөөлөлд өртөж буй айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний бэлтгэл ажил /Хууль эрх зүй, нийгэм эдийн засгийн чиглэлээр НҮТББ-тай хамтран ажиллах/ төсөл, арга хэмжээг 62,165,000 /жаран хоёр сая нэг зуун жаран таван мянга/ төгрөгөөр гүйцэтгэхээр 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн в/3451 тоот албан бичгээр гэрээ байгуулах эрх олгосон боловч хууль болон зарим эрхзүйн актуудыг зөрчиж байсан тул “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох,

ашиглах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.14-т "Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын 4.13-т заасан хөрөнгийг газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ" гэж заасны дагуу гэрээ байгуулж нөхөн олговор олгох ажлыг Увс, Баян-Өлгий аймгуудын засаг дарга нарт шилжүүлсэн.

5.5 Нөлөөлөлд өртөж буй айл өрхийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын гэрээг хуулийн хүрээнд шийдвэрлэх

Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тухай хүчин төгөлдөр байгаа хуулиуд нь:

- ✓ Үндсэн хууль (1992);
- ✓ Газрын тухай хууль (2002);
- ✓ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003);
- ✓ Монгол Улсын иргэний хууль (2002);
- ✓ Засгийн газраас баталсан газрын үнэлгээ, тариф (Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоол);
- ✓ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2018);

Монгол Улсын үндсэн хууль болон холбогдох хуульд, "Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно" гэж заасан бөгөөд "Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэж тогтсон байдаг.

Газрын тухай хуульд эзэмших эрх нь дуусгавар болсон тохиолдолд хэрхэн газар чөлөөлөхийг зохицуулсан байдаг. Өмчлөх эрх нь дууссан газар эзэмшигчийг хууль бус газар эзэмшигч гэж тооцох бөгөөд Газрын тухай хуулийн 27.4 дүгээрт "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно" гэж заасны дагуу нүүлгэн шилжүүлнэ. Тус хуулийн 16, 20 дугаар заалтад иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай тусгасан байна.

Төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийг хийхдээ Монгол улсын Иргэний хуулийн дагуу нөлөөлөлд өртсөн иргэдтэй харилцан тохиролцож, гэрээ байгуулах зарчмыг үндэслэл болгоно.

Тус өмгөөллийн гүйцэтгэх ажлын хүрээнд "Өмгөөллийн Эл Эм Эл Фирм" ХХН нь Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй айл өрх, иргэн, хуулийн этгээдэд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай, Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт амьдарч, МАА эрхэлж байгаа иргэний газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай гэрээ, Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэг удаагийн нөхөх олговор оруулах тухай санал боловсруулах болон шаардлагатай хууль, журамд өөрчлөлт оруулахад болон бусад ажилд хууль зүйн мэргэжлийн зөвлөгөөг өгч ажилласан болно. Ажлын актаар дараах материалуудыг хүлээн авсан болно. Үүнд:

- ✓ Тайлан /1 нүүр/
- ✓ Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт иргэний эзэмшил, өмчлөлийн газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай гэрээний төсөл /3 нүүр/
- ✓ Нөхөх олговрын үнийн дүнг зөвшилцөх хуудас /1 нүүр /
- ✓ Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй иргэдэд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай гэрээ /3 нүүр/

- ✓ Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд оруулах санал /1 нүүр/
- ✓ Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барих ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай МУ-ын Засгийн газрын тогтоолын төсөл /1 нүүр /

5.6 Нөлөөлөлд өртөж буй айл өрх, түүх соёлын өвийн нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэрэгжилт, явцыг дүрсэн хэлбэрээр танилцуулах

Түүх соёлын өв, археологийн олдворыг авран хамгаалах ажлын нарийвчилсан судалгааны ажлыг Монгол улсын ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнтэй байгуулсан Г/22-21 (АҮГ2022/41) гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны баг Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст баг, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумын нутагт тус бүр нэг баг нийт 3 баг болон ажиллаж байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт Улсын тусгай хэрэгцээний газарт орших археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлын явцтай танилцаж 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр судалгааны багтай хамтран ажиллаж иргэдэд танилцуулга хийв.



Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутаг дэвсгэрт орших Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын ус хуримтлуулах, хиймэл нуур үүсэх талбайд далайн түвшнээс дээш 1325 м өндөртэй ус хуримтлуулах талбайн эргэлтийн 384 цэгийг тодорхойлж 208 цэгийг тэмдэгжүүлэх хээрийн хэмжилт судалгааны ажлын явцтай танилцсаныг зургаар баталгаажуулсан байна.

6 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар нэгтгэн үр дүнг боловсруулав.

Хүснэгт 4. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

дд	Нөлөөлөлд өртөх Түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн/
1	Археологийн түүх, соёлын дурсгалт зүйлс	Хайгуул, судалгаа	Төслийн хүрээнд тусгай хэрэгцээнд авсан 28000 га талбайд	78,526,800.0₮	Бүрэн хэрэгжсэн. Тайлангийн 6.1-д дэлгэрэнгүй тусгав. /Гэрээг хавсралтаар тусгав/
2	Палентлогийн түүх, соёлын дурсгалт зүйлс	Хайгуул, судалгаа		27,055,600.0₮	Бүрэн хэрэгжсэн. Тайлангийн 6.2-д дэлгэрэнгүй тусгав. /Гэрээг хавсралтаар тусгав/
3	Соёлын биет бус өв	Хайгуул, судалгаа		59,593,600.0₮	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэж заасан боловч БОННУ тайланд тусгагдсанаар тухайн сумуудад зонхилж байгаа казак үндэстэн, өөлд, дөрвөд, баяд, мянгад ястнуудын угсаа гарал, аж ахуй, шашин шүтлэг, оюуны соёлын хүрээ Монгол угсаатны соёл бүрэлдэн тогтоход нэгэн цөм болсоор иржээ. Эрдэнэбүрэнгийн УЦС баригдаж ашиглалтанд ороход эдгээр үндэстэн ястны ахуй, соёлд нэгдсэн байдлаар эерэг нөлөө үзүүлэхээс бус, тэдний ёс заншил, шашин шүтлэг, соёлын биет бус өвд нөлөөлөх сөрөг нөлөөлөл харагдахгүй гэж дүгнэсэн тул тус судалгааны ажлыг гүйцэтгэх зайлшгүй шаардлагагүй болно.

6.1 Археологийн түүх, соёлын дурсгалт зүйлс

Монгол улсын холбогдох хууль журмын дагуу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн төсөл хэрэгжүүлэх нэгж Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдын заагт баригдах “Эрдэнэбүрэн УЦС” төслийн тусгай хэрэгцээний талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгаа хийлгэх хүсэлт гаргасны дагуу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн төсөл хэрэгжүүлэх нэгж болон ШУА-ийн Археологийн хүрээлэн хооронд 2022 оны 04-р сарын 27-нд Ажил гүйцэтгэх гэрээ (АХ/2022_13 тоот) байгуулагдаж хайгуул судалгааны ажлыг ШУА-ийн Археологийн

хүрээлэнгийн зөвлөх багийн бүрэлдэхүүнээр хийж гүйцэтгүүлсэн болно. Тус судалгааны ажлын хүрээнд 4 боть тайланг хүлээлгэж өгсөн. Хайгуул судалгааны ажлын үр дүнгээс дурдвал:

Хайгуул судалгааны ажлын үр дүнд улсын тусгай хэрэгцээнд авсан талбай болон түүний орчмоос нийт 2121 археологийн дурсгал (тусгай хэрэгцээт талбайд 1924)-ыг бүртгэн баримтжуулснаас Увс аймгийн Өмнөговь сумын нутагт 833 (тусгай хэрэгцээт талбайд 644), Ховд аймгийн Мянгад сумын нутагт 220 (тусгай хэрэгцээт талбайд 219), Эрдэнэбүрэн сумын нутагт 98 (тусгай хэрэгцээт талбайд 96), Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт 970 (тусгай хэрэгцээт талбайд 965) дурсгалыг тус тус илрүүлэн бүртгэсэн байна. Эдгээр археологийн дурсгалууд нь он цагийн хувьд урьдчилсан байдлаар 5000 жилийн тэртээгээс буюу шинэ чулуун зэвсгийн үеэс өдгөө XX зууныг хүртэлх өргөн хүрээг хамрах бөгөөд чулуун зэвсгийн бууц суурин 3, хүрлийн үеийн булш, хиргисүүр 1687, тахилын байгууламж 44, буган хөшөө 2, хөшөө чулуу 76, хадны зураг 8, хүннү булш 94, үйлдвэрлэлийн газар 2, түрэгийн үеийн тахилын байгууламж 22, монгол булш 71, хадны оршуулга 3, XIII-XVII зууны үед холбогдох хийдийн туурь 1, төвөд бичээс 3, орчин үеийн оршуулга 1, он цаг тодорхойгүй дурсгал 104 тус тус багтана.

Улсын тусгай хэрэгцээнд авсан 28 000 (хорин найман мянган) га талбай болон түүний орчимд бүртгэн баримтжуулсан нийт 2121 археологийн дурсгалаас усан сан үүсэх 9000 (есөн мянга) га талбайд 694 дурсгал бүртгэгдэв. Үүнд: Увс аймгийн Өмнөговь сумын нутагт 369, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт 325 дурсгал тус тус хамаарч байна. Мөн “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн барилга, бүтээн байгуулалтын талбайд 20 дурсгал бүртгэгдсэнээс Увс аймгийн Өмнөговь сумын нутагт 1, Ховд аймгийн Мянгад сумын нутагт 7, Эрдэнэбүрэн сумын нутагт 12 дурсгал хамаарч, нийт 714 археологийн дурсгал усан сан болон барилга бүтээн байгуулалтын талбайд бүртгэгдсэн байна /“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” төслийн тусгай хэрэгцээний талбай; Увс аймгийн Өмнөговь сумын нутагт хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан/.



Зураг 11. Тахилын байгууламж



Зураг 12. Дугуй болон Чулуун дараастай булш



Зураг 13. Археологийн тайлан хүлээлгэж өгсөн нүүр

6.2 Палентлогийн түүх, соёлын дурсгалт зүйлс

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүсэлтээр Монгол улсын ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнтэй байгуулсан Г/22-21 (АУГ2022/41) дугаар гэрээний дагуу Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдын орчмын заагт баригдах төслийн палеонтологийн үлдвэр, тэдгээрийг агуулагч хурдасны судалгааг хийлгэв. Судалгааг дараах аргачлалын дагуу гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ✓ Тухайн бүс нутгийн 1:100,000 масштабтай топографийн зураг болон хиймэл дагуулын мэдээнд үндэслэн зураглал боловсруулах,
- ✓ Талбайн байршилыг сонгох
- ✓ Эртний амьтан, ургамлын үлдвэрийн мэдээлэл болон газарзүйн солбилцолыг тэмдэглэх, баримтжуулах зэрэг болно.

Судалгааны талбай ихэнх хэсэг буюу 65% орчим хувийг Палеозойн эриний ордовик /500-435 сая жил/, силүр /435-410 сая жил/, карбон /355-295 сая жил/, цаг үеийн гүний болон бялхмал галт уулын чулуулаг эзэлж байна. Нөлөөллийн талбайн үлдсэн хэсгийг Ховд голын хөндийг дагасан дөрөвдөгчийн ангилагдаагүй хурдас, голын эрэг орчимд хуримтлагдсан, элсэн чулуу, шавраас бүрдэх дөрөвдөгчийн настай (10,000 жилийн өмнөх) хурдас болон бага талбайд тархсан палеоген, неогений тунамал зузаалаг бүрдүүлж байна.

Судалгааны үр дүнгээс авч үзвэл дөрөвдөгчийн настай чулуулгаас эртний хөхтөн амьтан буюу 10,000 жилийн өмнө тус нутагт амьдарч байсан адуу маягийн амьтны үүдэн шүд бүхий эрүүний урд хэсгийг олсон. Олдворын ойр орчимд нарийвчилсан хайгуул хийсэн боловч биеийн бусад хэсгүүд олдоогүй бөгөөд өмнө нь төслийн талбай орчмоос эртний хөхтөн илэрч байгаагүй тул чулуулгийн геологи болон тафономийн шинжид үндэслэн тус үйлдвэр нь голын эрэг дагуу зөөгдөн хуримтлагдсан гэж дүгнэсэн байна.

<p>“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН ТАЛБАЙД ГҮЙЦЭТГЭСЭН ПАЛЕОНТОЛОГИЙН НӨӨЦ БАЯЛГИЙН ҮНЭЛГЭЭ (ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН, МЯНГАД, УВС АЙМГИЙН ӨМНОГОВЬ, БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЯННУУР СУМДЫН НУТАГ)</p> <p>Захиалагч: “Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц” төсөл хэрэгжүүлэх нэгж</p> <p>Гүйцэтгэгч: Палеонтологийн Хүрээлэн Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи</p> <p>2022 оны 8-р сар</p>	<p>“Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц” төслийн талбайд гүйцэтгэсэн палеонтологийн нөөц баялагийн үнэлгээ (Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдын нутаг)</p> <p>Гэрээний дугаар: Г/22-21 (АУГ/2022/41)</p> <p>Захиалагч: “Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц” Төсөл Хэрэгжүүлэх Нэгж</p> <p>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хуучингийн гудамж, Их Монгол оффис, 504 тоот</p> <p>Гүйцэтгэгч: Палеонтологийн Хүрээлэн Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи</p> <p>Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, С.Данзангийн гудамж 3/1</p> <p><i>[Signature]</i> З.Бадамхатан /Ph.D./, Судалгааны багийн ахлагч, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> Р.Барсболд (Академич), Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> С.Пүрэвсүрэн, Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> Э.Зориг, Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> Б.Буянтэгш, Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> С.Басанхүү, Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> Б.Ууганцэнэл, Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p> <p><i>[Signature]</i> Ц.Нямхуяг, Судалгааны багийн гишүүн, палеонтологич</p>
---	--

Зураг 14. Палеонтологийн тайлан хүлээлгэж өгсөн нүүр

7 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөн 2022 онд хэрэгжүүлсэнийг доорх хүснэгтээр тайлагнав.

Хүснэгт 5. БОМТ-г хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

ДД	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Зардлын төсвийн хэрэгжилт	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн/
1	Төсөл хэрэгжих тусгай хэрэгцээний газрын харилцааны асуудлаар танин мэдэхүй, соён гэгээрүүлэх ажлыг арилжааны болон орон нутгийн телевизүүд, мэдээллийн сайтуудаар дамжуулан өргөнөөр зохион байгуулах	Төсөл байрлах орон нутагт	16,780,000.0₮	Бүрэн хэрэгжсэн - Тайлангийн 7.1-д дэлгэрэнгүйг тусгав. /Гэрээг хавсралтаар тусгав/
2	Тусгай хамгаалалттай газрын аюулгүй байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтын ажил болон ТЖБОМТ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулалтын болон тулгарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн байгууллагатай хамтарч ажиллахад зарцуулах зардал	Үйл ажиллагааны хүрээнд	17,500,000.0₮	Бүрэн хэрэгжсэн - Тайлангийн 7.2-д дэлгэрэнгүйг тусгав. /Гэрээг хавсралтаар тусгав/

7.1 Төсөл хэрэгжих тусгай хэрэгцээний газрын харилцааны асуудлаар танин мэдэхүй, соён гэгээрүүлэх ажлыг арилжааны болон орон нутгийн телевизүүд, мэдээллийн сайтуудаар дамжуулан өргөнөөр зохион байгуулах

Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багын 125 өрх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 айлын 1241 иргэн төслийн нөлөөлөлд өртөхөөр Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан. МУ-ын ЭХ-ний сайдын А/235 дугаар тушаалаар шийдвэрлэсэн 2022 онд багтаан нүүлгэн шилжүүлэх эд хөрөнгийн нөхөн олговор, нэг удаагийн олговор олгох 91 айл өрх хэрхэн хамрагдаж байгааг сурталчилах, төслийн ач холбогдлын талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагааг орон нутгийн телевизүүдээр гаргахаар төлөвлөгөөнд тусгагдсан. Тус ажлын хүрээнд “Огторгуйн асар НМТөв НҮТББ Ховд телевиз”, “Саян телевиз”, “МВС телевиз”-тэй гэрээ байгуулан хамтарч ажиллав/Гэрээнүүдийг хавсралтаар тусгав/.

7.2 Тусгай хамгаалалттай газрын аюулгүй байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтын ажил болон ТЖБОМТ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулалтын болон тулгарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн байгууллагатай хамтарч ажиллах

Төслийн зүгээс Увс аймаг дах Цагдаагийн газартай №АҮГ-2022/62 дугаартай Хамтран Ажиллах Гэрээ /“Үндсэн Гэрээ”/-г 2022 оны 10 сарын 02-ны өдрөөс 2022 оны 10 сарын 31-ний өдөр хүртэл, нэмэлтээр № АҮГ-2022/62-ГНӨ-01 болон № АҮГ-2022/62-ГНӨ-02 дугаар бүхий гэрээг 2022 оны 11 сарын 21-ний өдрөөс 2022 оны 12 сарын 02-ны өдөр хүртэл байгуулан хамтран ажиллаж байна.

Тус хамтран ажиллах гэрээний зорилго нь Захиалагч байгууллагын хэрэгжүүлж буй “Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл”-ийн улсын тусгай зориулалтын 28000 га талбайн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын “Улиастай баг”-ийн нутагт нийтийн хэв журмыг сахиулах, гэнэтийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорисон байна/Гэрээг хавсралтаар тусгав/.

Хавсралт



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Газрын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/235 дугаар тушаалаар баталсан "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл"-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2022 оны зардлын төсвийн 1.1-т туссан нийт 1,320,511,900 төгрөгийн нөхөн олговор олгох Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 51 айл өрхийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Увс аймгийн Өмнөговь сумын 41 айл өрхийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 51 айл өрхтэй нүүлгэн шилжүүлэх гэрээ байгуулан эд хөрөнгийн нөхөн олговрын 70% буюу нийт 1,095,211,800 төгрөгийн санхүүжилтийг олгох эрхийг Баян-Өлгий аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/, Увс аймгийн Өмнөговь сумын 41 айл өрхтэй нүүлгэн шилжүүлэх гэрээ байгуулан эд хөрөнгийн нөхөн олговрын нийт 225,300,100 төгрөгийн санхүүжилтийг олгох эрхийг Увс аймгийн Засаг дарга /Ч.Чимэд/ нарт тус тус шилжүүлсүгэй

3. Хавсралтаар баталсан айл өрхөд олгох нөхөн олговрын санхүүжилтийн 603,049,500 төгрөгийг Эрчим хүчний сайдын 2022 оны төсвийн багцын урсгал зардлын "Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж"-ын зардлаас тооцон гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /З.Мөнх-Оргил/, 717,462,400 төгрөгийг "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл"-ийн "Айл өрхийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олгоорт зориулан шилжүүлсэн" зардлаас тооцон гаргахыг "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл"-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж /Ч.Гантулга/ нарт тус тус зөвшөөрч, эрх шилжсэн аймгуудын Засаг дарга нарт шилжүүлэхийг үүрэг болгосугай.

4. Эрх шилжсэн нүүлгэн шилжүүлэлтийн ажлын гүйцэтгэл, санхүүжилт, үр дүнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хяналт тавьж, тус яаманд тухай бүр танилцуулж ажиллахыг эрх шилжсэн аймгуудын Засаг дарга нарт болон "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл"-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж /Ч.Гантулга/-д тус тус даалгасугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600534

9021050939 CTC7530 5455000

Эрчим хүчний сайдын 2022 оны 12-дугаар сарын 06-ны өдрийн А/Тушаалын нэгдүгээр хавсралт

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт, Шар Цэхээ, Баяннуур багийн нөлөөлд өртөж буй 2022 онд нүүх иргэдийн жагсаалт

№	Айлын дугаар	Өрхийн тэргүүн	Эд хөрөнгийн нөхөн олговор /мян.төг/	Эд хөрөнгийн нөхөн олговрын 70% /мян.төг/	Өндөржилт
1	40	Далайхан Арналхан	55,424.1	38,796.9	1305
2	45	Наян Сагым	24,547.7	17,183.4	1305
3	46	Хадан Маулет	43,612.4	30,528.7	1305
4	47	Халас Түгелбай	25,447.7	17,813.4	1305
5	48	Халас Тилеубай	23,647.7	16,553.4	1305
6	49	Зулпас Лиза	24,547.7	17,183.4	1305
7	50	Хаблаш Авдраш	24,547.7	17,183.4	1305
8	51	Хавдалда Шоферхан	22,329.1	15,630.4	1305
9	52	Рамазан Еркебек	22,329.1	15,630.4	1305
10	53	Семсерхан Саулебек	22,329.1	15,630.4	1305
11	54	Алданыш Күзеубай	18,655.8	13,059.1	1305
12	55	Биеке Төлеухан	54,989.5	38,492.7	1305
13	57	Биеке Алдынаш	23,647.7	16,553.4	1305
14	58	Алданыш Төлеген	19,210.4	13,447.3	1305
15	59	Алдабергем Майрамбек	23,647.7	16,553.4	1305
16	60	Биеке Алдаберген	30,363.6	21,254.5	1305
17	62	Алдабергем Мереке	18,655.8	13,059.1	1305
18	1	Смагул Адыл	33,752.9	23,627.0	1315
19	65	Ханатбай Тойшыбай	21,489.1	15,042.4	1305
20	69	Аман Бахытбек	29,599.6	20,719.7	1305
21	70	Байсолтан Кенжебек	16,931.8	11,852.3	1305
22	71	Турпанбай Сандалхан	9,166.6	6,416.6	1305
23	72	Жансейт Даулетхан	29,599.6	20,719.7	1305
24	74	Хаби Икранбек	42,712.4	29,898.7	1305
25	75	Жетабай Ашир	15,267.8	10,687.5	1305
26	76	Сагш Оналбек	28,699.6	20,089.7	1305
27	82	Айдарбек Хуатай	19,210.4	13,447.3	1305
28	84	Ханабай Женисхан	11,939.9	8,357.9	1305
29	85	Ханабай Мухтар	16,931.8	11,852.3	1305
30	90	Шауа Арганбай	56,203.6	39,342.5	1305
31	21	Алдаберген Мерземхан	7,616.9	5,331.8	1310
32	2	Смагул Хабыл	33,846.7	23,692.7	1315
33	23	Хадан Тилеухан	7,229.7	5,060.8	1310
34	35	Солткей Адис	65,617.0	45,931.9	1310
35	37	Хосылбай Есентай	82,764.8	57,935.4	1310
36	38	Ахметбай Ажкей	27,103.7	18,972.6	1310
37	39	Наби Шарипбай	51,466.9	36,026.8	1310
38	41	Багдал Мерамгүл	26,766.3	18,736.4	1310
39	44	Хуанбай Амирхан	29,599.6	20,719.7	1310
40	56	Төлеухан Тилеген	16,931.8	11,852.3	1310
41	73	Шошай Хайрат	26,203.7	18,342.6	1310
42	78	Ербала Кенжебек	21,429.1	15,000.4	1310
43	81	Айдарбек Базархан	34,939.5	24,457.7	1310
44	86	Рамазан Өсерхан	56,203.6	39,342.5	1310
45	88	Көжебай Бахтыбала	63,984.0	44,788.8	1310
46	89	Хиса Бердиболат	24,547.7	17,183.4	1310
47	92	Адис Байболат	17,831.8	12,482.3	1310
48	93	Адис Айболат	18,386.5	12,870.6	1310
49	94	Көктэй Хуатхан	59,321.4	41,525.0	1310
50	96	Мухамеди Шамей	55,424.1	38,796.9	1310
51	98	Турсын Айбек	27,935.6	19,554.9	1310
Нийт			1,564,588.3	1,095,211.8	

Эрчим хүчний сайдын 2022 оны 12 дугаар сарын 06-ны
 өдрийн А... тушаалын хоёрдугаар хавсралт
 1249

Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн
 нөлөөлөлд өртөж буй 2022 онд нүүх иргэдийн жагсаалт



№	Айлын дугаар	Өрхийн тэргүүн	Эд хөрөнгийн нөхөнст олговор 100% тэмдэгт	Өндөржилт
1	3	Н.Лхагва	2,826.0	1305
2	4	Ж.Намсрай	731.2	1305
3	5	Ч.Түмэннасан	4,881.4	1305
4	6	Д.Балсанжамц	2,963.6	1305
5	7	Т.Даваа	36,900.8	1305
6	8	Н.Балжинням	962.6	1305
7	9	Д.Цэрэнсамбуу	2,822.4	1305
8	10	Б.Сугаржав	2,822.4	1305
9	11	Т.Батхүү	1,860.5	1305
10	12	З.Цагаач	5,520.8	1305
11	13	А.Схаан	1,813.8	1305
12	14	Л.Энхбаатар	2,048.3	1305
13	16	Д.Жамсран	4,330.3	1305
14	17	Д.Сэргэлэн	5,888.1	1305
15	18	Н.Хүдрээ	14,681.5	1305
16	19	С.Ганбаатар	4,461.0	1305
17	20	С.Гантулга	4,427.7	1305
18	21	Ж.Баттулга	3,519.5	1305
19	23	Я.Сэндэнжав	2,463.4	1305
20	24	Ц.Отгонжаргал	5,235.7	1305
21	25	Х.Балган	1,320.9	1305
22	26	Б.Амгаланбаяр	5,566.8	1305
23	27	Б.Даньхүрэл	2,463.4	1305
24	58	Б.Цогоо	3,154.1	1305
25	59	Х. Должин	1,093.6	1305
26	60	Ц.Лхамжав	2,228.9	1305
27	79	Б.Мэндбаяр	3,603.0	1305
28	86	Ж.Мягмаржав	1,352.6	1305
29	90	Д.Мягмарсүрэн	2,463.3	1305
30	107	Я.Лхагва	3,188.4	1305
31	108	Д.Мягмаржав	1,321.3	1305
32	114	Ц.Батболд	2,098.3	1305
33	124	А.Нохойжав	862.4	1305
34	15	Ж.Ивгээл	3,549.8	1310
35	28	Н.Сүх-Очир	3,053.7	1310
36	30	С.Гантөмөр	29,663.1	1310
37	80	Н.Баттулга	3,187.6	1310
38	81	П.Баасанхүү	2,329.5	1310
39	109	Н.Нямаахүү	3,419.6	1310
40	112	Я.Пүрэвжав	2,826.0	1310
41	40	Э.Ганзориг	35,392.8	1315
Нийт			225,300.1	



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/235

Улаанбаатар хот

Зардлын төсвийг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл"-ийн Төслийн удирдах хорооны 2022 оны 08 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрчим хүчний сайдын 2022 оны урсгал зардалд батлагдсан "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл"-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г хэрэгжүүлэх 2022 оны зардлын төсвийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Хавсралтаар баталсан зардлыг Эрчим хүчний сайдын 2022 оны урсгал зардлын "Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" эдийн засгийн ангиллаас санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /З.Мөнх-Оргил/-т зөвшөөрсүгэй.

3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд тусгагдсан төслийн нөлөөлөлд өртөж буй Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 51, Увс аймгийн Өмнөговь сумын 40 айл өрхөд нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд олгох нөхөн олговрын санхүүжилтийн эрхийг аймгуудын Засаг дарга нарт шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Тавинбэх/-д даалгасугай.

4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд тусгагдсан Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт баг, Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч, мөн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Тавинбэх/-д даалгасугай.

5. Төслийн нөлөөлөлд өртөж буй айл өрх, иргэдтэй байгуулах гэрээний төсөл боловсруулах, мэдээллийн сан үүсгэх, түүх, соёлын өвийг хамгаалах болон БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлж ажиллахыг "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл"-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж /Ч.Гантулга/-д үүрэг болгосугай.

170600550

6. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу санхүүжүүлж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Тавинбэх/-д даалгасугай.

7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/108 дугаар тушаалыг хүчингүй болсон тооцсугай.



Эрчим хүчний сайдын 2022 оны // дугаар сарын // -ны өдрийн // бушаалын хавсралт



**“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

/мянган төгрөгөөр/

№	Зардлын үзүүлэлт	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	2022 оны зардлын төсөв
1	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	2022	2023	1,837,480.3
1.1	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 51, Увс аймгийн Өмнөговь сумын 40 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	2022	2023	1,320,511.9
1.2	Шинээр барих Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн зураг төсөл боловсруулах ажил	2022	2022	236,276.7
1.3	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл, 160 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл, 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөл боловсруулах ажил	2022	2022	189,691.7
1.4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний бэлтгэл ажил /Хөдөө аж ахуй, Байгаль орчны хүрээнд ТББ-тай хамтран ажиллах/	2022	2022	70,000.0
1.5	Нөлөөлөлд өртөж буй айл өрх, иргэдтэй нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын болон нэг удаагийн нөхөн төлбөр олгох гэрээний төслийг хуулийн фирмээр хийлгэх, хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт бэлтгэх, эрхзүйн зөвлөгөө авах	2022	2022	10,000.0
1.6	Нөлөөлөлд өртөж буй айл өрх, түүх соёлын өвийн нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэрэгжилт, явцыг дүрсэн хэлбэрээр танилцуулах програм хангамж боловсруулах зардал	2022	2022	11,000.0
2	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	2022	2023	165,176.0
2.1	Археологийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн хайгуул, судалгаа	2022	2022	78,526.8
2.2	Палеонтологийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн хайгуул, судалгаа	2022	2022	27,055.6
3	Соёлын биет бус өвийн хайгуул, судалгаа	2022	2022	59,593.6
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	2022	2023	34,280.0

4.1	Төсөл хэрэгжих тусгай хэрэгцээний газрын харилцааны асуудлаар танин мэдэхүй, соён гэгээрүүлэх ажлыг арилжааны болон орон нутгийн телевизүүд, мэдээллийн сайтуудаар дамжуулан өргөнөөр зохион байгуулах	2022	2024	16,780.0
4.2	Тусгай хамгаалалттай газрын аюулгүй байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтын ажил болон ТЖБОМТ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулалтын болон тулгарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн байгууллагатай хамтарч ажиллахад зарцуулах зардал	2022	2024	17,500.0
Дүн				2,036,936.3

НӨХӨХ ОЛГОВРЫН ГЭРЭЭ

Энэхүү гэрээг

Нэг талаас аймгийн Засаг даргын тамгын газар, түүнийг төлөөлж
..... /цаашид “А” тал гэх/,

Нөгөө талаас аймгийн сумын багийн газар
оршин суугч ургийн овогтой –н \рд: \ /цаашид
“Б” тал гэх/ нар “Газрын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3 зүйл, мөн
хуулийн 42 дүгээр зүйл, 43 дугаар зүйл болон бусад холбогдох хууль тогтоомжийг
үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

- 1.1. Гэрээний зорилго нь Монгол улсын Засгийн газар (цаашид “МУЗГ” гэх)-ын 2019 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн 357 тоот тогтоолын дагуу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” (цаашид “ТӨСӨЛ” гэх)-ийг хэрэгжүүлэх 28000 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсантай холбогдуулан төслийн барилга, байгууламж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор газар чөлөөлөх, нөлөөлөлд өртөж буй айл өрхүүдэд нөхөн олговор олгох, газрыг улсын тусгай хэрэгцээнд эргүүлэн авах, бүртгэх болон гэрээ дуусгавар болох үндэслэл, Талуудын хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Талууд уг Гэрээнд заасан түүгээр тодорхойлогдсон эрх, үүргийг заавал биелүүлэх үүрэг хүлээж харилцан тохиролцов.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ НӨХӨН ОЛГОВРЫН ХЭМЖЭЭ

- 2.1. Төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэн Гэрээний талуудын харилцан зөвшилцөж тохиролцсоны дагуу нөлөөлөлд өртсөнм.кв газар болон газарт байрлах дагалдах бүхий л эд хөрөнгө (байшин, малын хашаа, саравч, худаг зэрэг)-ийн нөхөн олговрын хэмжээтөгрөг байна.
- 2.2. Гэрээний талууд гэрээг байгуулсан цаг хугацаанаас хойш ажлын 30 хоногийн дотор Гэрээний 2.1-д заасан нөхөх олговрын үнийн дүнгийн 60 хувь буюу.....төгрөгийг олгох бөгөөд нөхөх олговрын урьдчилгаа төлбөр хүлээн авснаас хойш газрыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор чөлөөлсөн тохиолдолд нөхөх олговрын дүнгийн 40 хувь буюу.....төгрөгийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан олгоно.
- 2.3. Нөхөх олговрыг хүлээн авах банк болон дансны мэдээлэл:
а\банкны тоот данс
б\.....

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. “А” талын эрх, үүрэг:

- 3.1.1. Гэрээний талууд гэрээг байгуулж баталгаажуулснаас хойш “Б” талд Гэрээний 2.1-д заасан нөхөн олговрыг гэрээний 2.2-д заасан цаг хугацаанд олгох үүрэгтэй.

- 3.1.2. “А” тал нь “Б” талаас өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар өмчлөх, эзэмших, ашиглах гэрээг дуусгавар болгох эсвэл эд хөрөнгийг шилжүүлэх, хүчингүй болгох хүсэлт, мэдүүлгийг гэрээ байгуулах цаг хугацаанд гаргаж өгөхийг шаардах эрхтэй.
 - 3.1.3. Гэрээнд заасан хугацаанд “Б” тал газар чөлөөлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд улсын тусгай хэрэгцээний газрыг хууль бусаар өмчилсөн, эзэмшсэн, ашигласантай адилтгаж уг газрыг үл маргах журмаар албадан чөлөөлөх эрхтэй.
 - 3.1.4. “Б” талаас иргэн, хуулийн этгээдэд нөхөх олговор олгогдоход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, нэмэлт баримт бичгийг шаардан гаргуулах, шаардлагатай тохиолдолд “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих мэдээлэл гаргуулах зөвшөөрлийг авах, гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
 - 3.1.5. Талууд гэрээг байгуулж нөлөөлөлд өртөж нөхөх олговрын урьдчилгааг “Б” талд олгосон тохиолдолд Гэрээний 3.1.2-т заасан хүсэлт, мэдүүлэг бусад баримтын хамт газрын албанд хүргүүлж мэдээллийн санд хасалт хийх, хүчингүй болгуулах үйл ажиллагааг хийх үүргийг хүлээнэ.
 - 3.1.6. Нөхөх олговрын төлбөрийг “Б” талд бүрэн олгож Гэрээнд заасан чөлөөлөх хугацаа өнгөрмөгц газрыг хамгаалах хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах эрхтэй.
- 3.2. “Б” талын эрх, үүрэг:**
- 3.2.1. Гэрээний 2.1-д заасан нөхөн олговрыг гэрээний 2.2-д заасан цаг хугацаанд олгохыг “А” талаас шаардах эрхтэй.
 - 3.2.2. Нөхөх олговор олгох тухай гэрээ байгуулахдаа газар болон үл хөдлөх, дагалдах эд хөрөнгийн эрхтэй холбоотой шаардах эрхээс татгалзсан, шилжүүлэхийг зөвшөөрсөн зөвшөөрлийн хүсэлт, мэдүүлгийг “А” талд хүлээлгэн өгөх үүрэгтэй. Нөхөх олговор олгох тухай гэрээ байгуулахдаа иргэн, хуулийн этгээд нь үл хөдлөх эрхийн гэрчилгээг хүчингүй болгох хүсэлт, мэдүүлгийг бөглөн “А” талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
 - 3.2.3. Нөхөх олговор олгох баримт бичгийн бүрдэл, газар болон эд хөрөнгийн үнэн зөв байдлыг “А” талын өмнө бүрэн хариуцна.
 - 3.2.4. Газар болон үл хөдлөх эд хөрөнгө хамтран өмчлөгч, эзэмшигчтэй тохиолдолд газар, үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах, гэрээнд төлөөлөн оролцох, нөхөн олговрын төлбөрийг хүлээн авахыг зөвшөөрсөн итгэмжлэлийг хамтран өмчлөгчдөөс гаргуулан “А” талд хүлээлгэн өгнө.
 - 3.2.5. “Б” тал нь нөлөөлөлд өртсөн газар болон эд хөрөнгийг бусдад худалдан борлуулах гэрээ хэлцэл байгуулсан, барьцааны эрх үүссэн тохиолдолд гуравдагч этгээдийн талаар зохих үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.
 - 3.2.6. “Б” тал нь нөхөх олговрын урьдчилгаа төлбөрийг хүлээн авсан даруй 14-21 хоногийн дотор гэрээнд заасан газрыг чөлөөлөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлсэн тохиолдолд нөхөх олговрын үлдэгдэл төлбөр авах эрх үүснэ.
 - 3.2.7. “Б” тал нь өөрийн өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгийг чөлөөлөх, буулгах үеийн аюулгүй ажиллагааг хариуцах бөгөөд чөлөөлж байгаа газарт байрлах хүн,

мал унаж бэртэх эрсдэлтэй нүхийг булж битүүмжлэх, хог хаягдлыг бөөгнүүлэн зөөж тээвэрлэхэд бэлэн байдлыг хангаж хүлээлгэн өгнө.

- 3.2.8. Нөхөх олговрыг хүлээн авсан боловч газар, үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг чөлөөлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд олгосон нөхөх олговрын үнийн дүнгээс 0.5 хувийн алданги, торгуулийг “А” талд төлнө.

ДӨРӨВ. БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ

- 4.1. “А” тал нь Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бүрэн биелүүлэх болохоо энэхүү заалтаар “Б” талд баталгаа, мэдэгдэл гаргаж байна.
- 4.2. “Б” тал нь нөхөх олговрын төлбөр хүлээн авсан даруй газар чөлөөлөх үүргээ заавал биелүүлэх баталгааг энэхүү гэрээний заалтаар “А” талд гаргаж байна.
- 4.3. “Б” тал нь энэхүү Гэрээг ямар нэгэн ноцтой төөрөгдөл, бусдын дарамт шахалтад ороогүй бөгөөд өөрийн хүсэл зоригоо илэрхийлж байгуулсан болно.
- 4.4. Гэрээнд дурдагдаж буй газар, эд хөрөнгөтэй холбоотой гуравдагч этгээдийн нэхэмжлэл, маргаан байхгүй, шүүх арбитрын ажиллагаа байхгүй, барьцааны эрх үүсээгүй болохыг баталж байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.
- 5.1.1. Гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд нөхөх олговрыг бүрэн олгож, газрыг чөлөөлж улсын тусгай хэрэгцээнд бүртгэснээр дуусгавар болно.
- 5.1.2. Газар чөлөөлөх нөхцөлийн талаар гэрээний талуудын хооронд хийсэн нөхөх олговрын мөнгөн дүнг зөвшилцөх хуудас болон түүний хавсралт баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 5.1.3. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргаантай асуудлыг Талууд харилцан тохиролцож үл маргах журмаар шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

..... аймгийн Засаг даргын тамгын
газар, түүнийг төлөөлж
...../албан тушаал, нэр/
Утас:

..... аймгийн сумын
..... багийн газар
оршин суугч ургийн
овогтой –н/нэр/
Утас:

НӨХӨХ ОЛГОВРЫН ҮНИЙН ДҮНГ ЗӨВШИЛЦӨХ ХУУДАС

2022.....сарын.....-ны өдөр

№

Иргэний овог нэр, регистрийн дугаар: овог, нэр, регистрийн дугаар

Хаяг: байршил, хаяг

Нэгж талбарын дугаар /PID, координат/: дугаар, координат

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 357 дугаар тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан газар буюу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн усан сан үүсэх аймгийн сумын багийн нутагт нөлөөлөлд өртөж буй иргэн ургийн овогтой –н (РД:)-н өөрийн болон гэр бүлийнга газар, түүнтэй дагалдах үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговрын үнийн дүнг Зөвшилцөх хуудас болно.

2. Эд хөрөнгийн үнэлгээ:

Нөхөх олговрын зүйл	Гэрчилгээний дугаар	Нөлөөлөлд өртсөн хэмжээ / м ² /	Үнэлгээ /төг/
Газар	гэрчилгээний дугаар	хэмжээ м ²	үнэлгээ төг
Барилга, байгууламж	бүртгэлийн дугаар	талбай м ²	үнэлгээ төг
Бусад үл хөдлөх хөрөнгө	-	-	үнэлгээ төг
Нүүлгэн шилжүүлэх зардал			
Нийт			нийлбэр дүн төг

ЗӨВШИЛЦСӨН:

- Дээрх нөхөх олговрын нийт үнийн дүнг хүлээн зөвшөөрч, цаашид санал, гомдолгүй болохыг мөн нөхөх олговор, нүүлгэн шилжүүлэлтийн талаар ямарваа байдлаар маргаан үүсгэхгүй болохыг үүгээр баталж байна.
- Дараах баримт бичиг нь энэхүү Зөвшилцөх хуудасны салшгүй хэсэг болох ба нөхөх олговортойгоор газар эргүүлэн авах тухай гэрээний үндэслэл болно. Үүнд:
 - аймгийн/сумын бүртгэлийн албанаас гаргасан оршин суугаа хаягийн тодорхойлолт
 - Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн зөвшилцсөн тохиолдолд /насанд хүрээгүй Хүүхдийн эцэг, эх/ нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл
 - Газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах газрын хил зааг, байршил кадастрын зураг
 - Барилга байгууламж, бусад үл хөдлөх хөрөнгийн зураг

..... аймгийн Засаг даргын тамгын газар,
түүнийг төлөөлж/албан
тушаал, нэр/
Утас:

..... аймгийн сумын
багийн газар оршин суугч
..... ургийн овогтой –н
...../нэр/
Утас:

УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВСАН ГАЗАРТ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨЖ БУЙ ИРГЭДЭД НЭГ УДААГИЙН НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ

Энэхүү гэрээг

Нэг талаасаймаг..... сумын Засаг даргын тамгын газар, түүнийг төлөөлж
..... /цаашид “А” тал гэх/,

Нөгөө талаас аймгийн сумын багийн газар
оршин суугч ургийн овогтой –н \рд: \ /цаашид “Б” тал
гэх/ нар Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146
дугаар тогтоолыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

- 1.1. Гэрээний зорилго нь Монгол улсын Засгийн газар (цаашид “МУЗГ” гэх)-ын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 160 тоот тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” (цаашид “ТӨСӨЛ” гэх)-той холбогдуулан төслийн барилга, байгууламж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх зорилготой Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146 дугаар тогтоолын дагуу нөлөөлөлд өртөж буй айл өрхийн иргэн бүрд нэг удаагийн нөхөн олговор олгох болон Талуудын хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Талууд уг Гэрээнд заасан түүгээр тодорхойлогдсон эрх, үүргийг заавал биелүүлэх үүрэг хүлээж харилцан тохиролцов.

ХОЁР. НЭГ УДААГИЙН НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ НӨХЦӨЛ, ХЭМЖЭЭ

- 2.1. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146 дугаар тогтоолын 3 дугаар хэсэгт заасны дагуу нөлөөлөлд өртсөн айл өрхийн иргэн бүрд нэг удаагийн нөхөн олговрын хэмжээ 15,200,000 \арван таван сая хоёр зуун мянган\ төгрөг байна.
- 2.2. Нэг удаагийн нөхөн олговрыг нөлөөлөлд өртсөн газар нутагт байнга оршин суудаг, засаг захиргааны нэгжид бүртгэл бүхий иргэдэд олгоно.
- 2.3. Гэрээний талууд гэрээг байгуулсан цаг хугацаанаас хойш Засгийн Газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд нэг удаагийн нөхөн олговор олгоно.
- 2.4. Нэг удаагийн нөхөн олговрыг хүлээн авах иргэний болон түүнтэй хамаарал бүхий этгээд нарын мэдээлэл
 - а\
 - б\
- 2.5. Нэг удаагийн нөхөн олговор хүлээн авах банк болон дансны мэдээлэл:
 - а\банкны тоот данс
 - б\.....

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. “А” талын эрх, үүрэг:

- 3.1.1. Гэрээний талууд гэрээг байгуулж Гэрээний 2.2-д заасан нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд нөлөөлөлд өртсөн айл өрхийн иргэн бүрд Гэрээний 2.1-д заасан нэг удаагийн нөхөн олговор олгох үүрэгтэй.
 - 3.1.2. Энэхүү гэрээг байгуулах үедээ “Б” талаас нэг удаагийн нөхөх олговор олгосон тохиолдолд өмчлөл, эзэмшил, ашиглаж байгаа газрыг нэн даруй чөлөөлөх тухай баталгааг өрхийн насанд хүрсэн иргэн бүр бичгээр гаргахыг шаардах эрхтэй.
 - 3.1.3. “А” тал нь нэг удаагийн нөхөн олговор олгосон даруй “Б” талаас өөрийн өрхийн буюу өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрыг чөлөөлөх, өмчлөх, эзэмших, ашиглах гэрээг дуусгавар болгох эсвэл эд хөрөнгийг шилжүүлэх, хүчингүй болгох хүсэлт, мэдүүлгийг нэн даруй эрх бүхий холбогдох байгууллагад гаргаж өгөхийг шаардах эрхтэй.
 - 3.1.4. “А” тал Гэрээний 2.1-д заасан үүргээ биелүүлсэн тохиолдолд “Б” тал газар чөлөөлөх үүргээ нэн даруй биелүүлээгүй тохиолдолд нэг улсын тусгай хэрэгцээний газрыг хууль бусаар өмчилсэн, эзэмшсэн, ашигласантай адилтгаж уг газрыг албадан чөлөөлөх эрхтэй.
 - 3.1.5. Гэрээний “А” тал “Б” талаас нэг удаагийн нөхөн олговор олгогдоход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, нэмэлт баримт бичиг болон шаардлагатай тохиолдолд “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих мэдээлэл гаргуулах зөвшөөрлийг авах эрхтэй.
 - 3.1.6. “А” тал нөлөөлөлд өртөж нэг удаагийн нөхөн олговрыг “Б” талд олгосон тохиолдолд Гэрээний 3.1.2-т заасан хүсэлт, мэдүүлэг бусад баримтын хамт газрын албанд хүргүүлж мэдээллийн санд хасалт хийх, хүчингүй болгуулах үйл ажиллагааг хийх үүргийг хүлээнэ.
 - 3.1.7. “А” тал гэрээнд заасан нэг удаагийн нөхөн олговрыг “Б” талд бүрэн олгож Гэрээнд заасан чөлөөлөх хугацаа өнгөрмөгц газрыг хамгаалах хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах эрхтэй.
- 3.2. “Б” талын эрх, үүрэг:**
- 3.2.1. Гэрээний 2.1-д заасан нөхөн олговрыг гэрээний 2.2-д заасан нөхцөл байдал бүрдсэн даруй олгохыг “А” талаас шаардах эрхтэй.
 - 3.2.2. Энэхүү гэрээг байгуулах үедээ “А” талд нэг удаагийн нөхөх олговор олгосон тохиолдолд өмчлөл, эзэмшил, ашиглаж байгаа газрыг нэн даруй чөлөөлөх тухай баталгааг өрхийн насанд хүрсэн иргэн бүр бичгээр гаргах бөгөөд гэрээг төлөөлөн байгуулж байгаа этгээдэд энэхүү гэрээг зөвшөөрсөн, газар чөлөөлөхөд татгалзалгүй тухай болон гэрээ байгуулах эрх олгосон, нөхөн олговрыг хүлээн авахыг зөвшөөрсөн итгэмжлэл олгоно.
 - 3.2.3. Нэг удаагийн нөхөх олговор олгох баримт бичгийн бүрдэл, газар болон эд хөрөнгийн эрхтэй холбоотой үнэн зөв байдлыг “А” талын өмнө бүрэн хариуцна.
 - 3.2.4. “А” талаас нэг удаагийн нөхөн олговрыг хүлээн авсан даруй буюу 30 хоногийн дотор “Б” тал нь өмчилсэн, эзэмшсэн, ашиглаж байгаа газрыг чөлөөлөх үүрэгтэй.

- 3.2.5. “Б” тал нь гэрээг байгуулж, нэг удаагийн нөхөн олговор авсан тохиолдолд гэрээнд зааснаас бусад байдлаар “А” талд нэхэмжлэл, ямар нэгэн шаардлага гаргах эрхгүй.
- 3.2.6. “Б” тал нь нэг удаагийн нөхөн олговор хүлээн авсан боловч Гэрээний 3.2.4-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд “А” талд хүлээн авсан мөнгөн дүнгийн хэмжээгээр 0.5 хувиар алданги төлөх үүрэгтэй.
- 3.2.7. “Б” тал нь нөлөөлөлд өртсөн газар болон эд хөрөнгийг бусдад худалдан борлуулах гэрээ хэлцэл байгуулсан, гуравдагч этгээдэд барьцааны эрх үүссэн тохиолдолд зохих үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.

ДӨРӨВ. БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ



- 4.1. “А” тал нь Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бүрэн биелүүлэх болохоо энэхүү заалтаар “Б” талд баталгаа, мэдэгдэл гаргаж байна.
- 4.2. “Б” тал нь нэг удаагийн нөхөн олговор хүлээн авсан даруй газар чөлөөлөх үүргээ заавал биелүүлэх баталгааг энэхүү гэрээний заалтаар “А” талд гаргаж байна.
- 4.3. “Б” тал нь энэхүү Гэрээг ямар нэгэн ноцтой төөрөгдөл, бусдын дарамт шахалтад ороогүй бөгөөд өөрийн хүсэл зоригоо илэрхийлж байгуулсан болно.
- 4.4. Гэрээнд дурдагдаж буй газар, эд хөрөнгөтэй холбоотой гуравдагч этгээдийн нэхэмжлэл, маргаан байхгүй, шүүх арбитрын ажиллагаа байхгүй, барьцааны эрх үүсээгүй болохыг баталж байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Гэрээг 3 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.
- 5.1.1. Гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд нөхөх олговрыг бүрэн олгож, газрыг чөлөөлж улсын тусгай хэрэгцээнд бүртгэснээр дуусгавар болно.
- 5.1.2. Газар чөлөөлөх нөхцөлийн талаар гэрээний талуудын хооронд хийсэн нөхөх олговрын мөнгөн дүнг зөвшилцөх хуудас болон түүний хавсралт баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 5.1.3. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргаантай асуудлыг Талууд харилцан тохиролцох журмаар шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАТЛАВ.



**ШИНЭЭР БАРИХ УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН УЛИАСТ БАГИЙН ТӨВИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар № *ЭХА/202205054*

Улаанбаатар хот

Нэг талаас **Эрчим хүчний яам** (цаашид ‘‘захиалагч’’ гэх), нөгөө талаас **‘‘Аркосис’’ ХХК** (цаашид ‘‘зөвлөх’’ гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож **2022** оны **08** сарын **30** - ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид ‘‘гэрээ’’ гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № -д тодорхойлсон ‘‘Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ’’-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид ‘‘үйлчилгээ’’ гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь **Шинээр барих увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн зураг төсөл боловсруулах ажлыг** (цаашид ‘‘ажил’’ гэх) **236,276,700 (хоёр зуун гучин зургаан сая хоёр зуун далан зургаан мянга долоон зуу)** (цаашид ‘‘гэрээний үнэ’’ гэх) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид ‘‘гэрээний баримт бичиг’’ гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ

Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь

Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь

Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг

Хавсралт №5 Захиалагчийн хүлээх үүрэг

Хавсралт №6 Урьдчилгаа төлбөрийн загварын маягт

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ХЯНАСАН:

Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга

Ж.Жанарбаатар

Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

Л.Мөнхжаргал

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн зохицуулагч
Ч.Гантулга

“Аркосис” ХХК-ийн менежер, Б.Анужин


ТАМГА

ТАМГА

УБ, БЗД, 26-р хороо, “Их Монгол”
оффис 504 тоот
77551516

УБ, СБД, 1-р хороо, “Люкс Центр” 1101
тоот
99102487, 99909579
Хас банк, 5001201643

БАТЛАВ.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН ЦЭЦЭГТ БАГИЙН ШИНЭ СУУРЬШЛЫН
БҮСИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ /160 ХҮҮХДИЙН
СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ, 50 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН
ИЖ БҮРЭН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар № ЭХ/202205055

Улаанбаатар хот

Нэг талаас **Эрчим хүчний яам** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **“Аркосис” ХХК** (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож **2022** оны **08** сарын 30 - ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № -д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь Баян-өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл /160 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл, 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын иж бүрэн зураг төсөл боловсруулах ажлын гэрээг (цаашид “ажил” гэх) **189,691,700.0 (Нэг зуун наян есөн сая зургаан зуун ерэн нэгэн мянга долоон зуу)** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ

Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь

Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь

Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг

Хавсралт №5 Захиалагчийн хүлээх үүрэг

Хавсралт №6 Урьдчилгаа төлбөрийн загварын маягт

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ХЯНАСАН:

Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын
газрын Санхүүгийн хэлтсийн дарга

Ж.Жанарбаатар

Эрчим хүчний яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

Л.Мөнхжаргал

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

**"Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан
станц" төслийн зохицуулагч
Ч.Гантулга**

"Аркосис" ХХК-ийн менежер, Б.Анужин

ТАМГА

ТАМГА

**УБ, БЗД, 26-р хороо, "Их Монгол"
оффис 504 тоот
77551516**

**УБ, СБД, 1-р хороо, "Люкс Центр" 1101
тоот
99102487, 99909579
Хас банк, 5001201643**

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ЭНЭХҮҮ ГЭРЭЭ НЬ:

НЭГ ТАЛААС: **Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл хэрэгжүүлэх нэгж** (цаашид «Үйлчлүүлэгч» гэх), түүнийг төлөөлж Төслийн зохицуулагч албан тушаалтай Чулуун овогтой Гантулга

НӨГӨӨ ТАЛААС: **“Өмгөөллийн Эл Эм Эл фирм” ХХН** (цаашид «Зөвлөх» гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Рагчаа овогтой Оюун-Эрдэнэ, (хамтад нь «Талууд» гэх), НАР ХАРИЛЦАН ТОХИРОЛЦСОНООР, Хууль зүйн зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэхэд талуудын хүлээх хариуцлага, төлбөр төлөх харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖИЛ


- 2.1. Үйлчлүүлэгч нь Зөвлөхөөр Эрдэнэбүрэнгийн УЦС төслийг хэрэгжүүлэхтэй холбогдох Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй айл өрх, иргэн, хуулийн этгээдэд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай, Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт амьдарч, мал аж ахуй эрхэлж буй иргэний газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай гэрээ, Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэг удаагийн нөхөх олговор олгох тухай оруулах санал боловсруулах болон шаардлагатай хууль, журамд өөрчлөлт оруулахад болон бусад ажилд хууль зүйн мэргэжлийн зөвлөгөөг өгөх ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тохиролцсон болно.
- 2.2. Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг мэргэжлийн түвшинд, бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хурдан шуурхай байдлаар гүйцэтгэнэ.
- 2.3. Зөвлөх нь үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагч талын зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.
- 2.4. Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд цаашид өөр үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулах зэрэгт өөрийн байгууллагыг сонирхлын зөрчилд орохоос зайлсхийнэ.
- 2.5. Нөхцөл байдлаас шалтгаалан талууд нэмэлт ажлын гэрээ байгуулж болох ба нэмэлт ажлын гэрээнд төлөөлөх ажлын нөхцөл байдал, гэрээний үнийн дүнг нэмэлтээр тодорхой тусгаж гэрээний хавсралтаар баталгаажуулна.
- 2.6. Нэмэлт ажил болон ажлын хөлсийг энэхүү гэрээний хавсралтаар баталгаажуулж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Гэрээ нь Талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээт ажлын үр дүнг ажил хүлээлцэх актын дагуу хүлээлгэн өгснөөр дуусгавар болно.
- 3.2. Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэх ажлын даалгаврын хугацааг талууд тухай бүрд тохиролцоно.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Гэрээний ажлын нийт төлбөр нь 10,000,000 (арван сая) төгрөг байна.
- 4.2. Ажлын урьдчилгаа төлбөр гэрээний 4.1-д заасан үнийн дүнгийн 50%-тай тэнцэх хэмжээтэй байх бөгөөд гэрээ батлагдсан өдрөөс хойш 5 хоногийн дотор Үйлчлүүлэгч тал Зөвлөх талд шилжүүлнэ.



АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. Гэрээний гүйцэтгэлийн явцад аль ч тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болох ба саналыг хүлээн авсан тал ажлын 5-аас доошгүй хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Талууд гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, харилцан тохиролцсон нөхцөлд гэрээнд болон түүний хавсралтад өөрчлөлт оруулж болно.
- 11.2. Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛ:

ЗӨВЛӨХ ТАЛ:

“Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл хэрэгжүүлэх нэгж”

Түүнийг төлөөлөн Нэгжийн зохицуулагч Ч.Гантулга

..... /гарын үсэг/

Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 26-р хороо, Их Монгол төв 504 тоот
РД: 9922431

Утас: 77551516

Факс:

Гар утас: 976-80110025, 99085599

И-мэйл хаяг:

info@erdeneburenhpp.mn

“Өмгөөллийн ЭЛ ЭМ ЭЛ фирм” ХХН,

Түүнийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Рагчаагийн Оюун-Эрдэнэ

..... /гарын үсэг/

Хаяг: Улаанбаатар хот, СБД, 9-р хороо, 7-р хороолол, Компьютер Молл оффис-1006/Б.

РД: 6498876

Утас: 976-7731-0746

Факс: 976-7731-0746

Гар утас: 976-9905-8410

И-мэйл хаяг: info@lmlpartners.mn

АЖИЛ ХҮЛЭЭЖ АВСАН ТУХАЙ АКТ

2022 он 11 сарын 30

Улаанбаатар хот

Гүйцэтгэгч: “Өмгөөллийн Эл Эм Эл Фирм” ХХН

Гүйцэтгэсэн ажил: Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй айл өрх, иргэн,хуулийн этгээдэд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай, Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт амьдарч, МАА эрхэлж байгаа иргэний газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай гэрээ, Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэг удаагийн нөхөх олговор оруулах тухай санал боловсруулах болон шаардлагатай хууль, журамд өөрчлөлт оруулахад болон бусад ажилд хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх

Гүйцэтгэсэн хугацаа: 2022 оны 7 сарын 22-нд эхэлж ажил хүлээж авах актаар ажлаа дүгнэснээр дуусгавар болно.

Хүлээж авсан материал:

1. Тайлан /1 нүүр/
2. Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт иргэний эзэмшил, өмчлөлийн газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай гэрээний төсөл /3 нүүр/
3. Нөхөх олговрын үнийн дүнг зөвшилцөх хуудас /1 нүүр /
4. Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй иргэдэд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай гэрээ /3 нүүр/
5. Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд оруулах санал /1 нүүр/
6. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барих ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай МУ-ын Засгийн газрын тогтоолын төсөл /1 нүүр /

Ажил хүлээж авсан он, сар, өдөр: 2022 оны 11-р сарын 23


Хүлээж авсан:


Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн
нэгжийн Гэрээ хэлцэл, нийгмийн
асуудал хариуцсан ажилтан


.....М.Бямбасайхан

Хүлээлгэн өгсөн:

“Өмгөөллийн Эл Эм Эл Фирм” ХХН
Гүйцэтгэх захирал


.....Р.Оюун-Эрдэнэ




БАТЛАВ:
ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Ч. ГАНУЛГА

БАТЛАВ:
ШУА-ИЙН АРХЕОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР



Г.ЭРЭГЗЭН

АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ АЖЛЫН ГЭРЭЭ

2022 оны 04 дүгээр сарын
27-ны өдөр

Дугаар № *АХ/2022-13*
АХТ-2022/42

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж, түүнийг төлөөлж Төслийн зохицуулагч Ч.Гантулга (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ШУА-ийн Археологийн хүрээлэн, түүнийг төлөөлж захирал, доктор (Ph.D), дэд профессор Г.Эрэгзэн (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭ (цаашид “гэрээ” гэх)-г байгуулав.

1. Захиалагч нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан археологийн хайгуул судалгааны ажлыг Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын нутаг дахь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 28,000 га талбайд (цаашид “ажил” гэх) гүйцэтгэхийг Гүйцэтгэгчид даалгаж, түүнтэй холбогдон гарах хөлсийг төлөх ба Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд холбогдох хууль, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэхтэй холбогдсон харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой болгон зохицуулна.
2. Гүйцэтгэгч нь Захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Ажлын нийт хөлс нь 78,526,800.00 (далан найман сая таван зуун хорин зургаан найман зуу) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Энэ нь Гүйцэтгэгч энэ гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд шаардлагатай (холбогдох татвар, хураамж, бусад) бүх зардлууд багтсан эцсийн үнэ болно. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт:

Хавсралт №1 Ажлын даалгавар

Хавсралт №2 Ажил гүйцэтгэх хуваарь

Хавсралт №3 Багийн бүрэлдэхүүний мэдээлэл

Хавсралт №4 Ажлын зардлын задаргаа

Хавсралт №5 Төлбөр гүйцэтгэх хуваарь

Хавсралт №6 Гүйцэтгэгчийн ажлын туршлага, ажиллах хүчний мэдээлэл

Гэрээ нь дор дурдсан үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон Гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Гэрээнд тусгайлан заагаагүй бол Ажил гүйцэтгэхэд гарах шаардлагатай бүх зардал (тээвэр, холбоо, материал хүргэлт, орчуулга, хэвлэлт гэх мэт)-уудыг


13. Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

14. Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээ, гаргасан дүгнэлт, тайлангийн үнэн зөвийг гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцаж хамгаална.

15. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСЛИЙН ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ,
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АЖИЛТАН
Д. БЯМБАЦЭРЭН



ТӨСЛИЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН
АЖИЛТАН Б. ОТГОН

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДОКТОР (Ph.D) Н. ЭРДЭНЭ-ОЧИР



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайван өргөн чөлөө гудамж,

ШУА-ийн Нэгдсэн I байр

[Утас: 452894, 91069595; факс: 452899]

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16-р
хороо, Их Монгол гудамж, Их Монгол Төв,
5 давхар, 504 тоот
Утас: 77551516, 99085599

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

2022 оны 07 сарын 20 өдөр

Гэрээний нэр	Ажил гүйцэтгэх
Гэрээний дугаар	АҮГ/2022/42
Захиалагч	“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөл
Гүйцэтгэгч байгууллага	Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэн
Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа	2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр
Гэрээгээр ажил дуусах хугацаа	2022 оны 7 дугаар сарын 30-ны өдөр
Гэрээний дүн	78,526,800.00 төг

Батлагдсан дүн:

78,526,800.00 төгрөг

Санхүүжилтийн дүн:

78,526,800.00 төгрөг

Ажлын гүйцэтгэл	39,263,400.00	Үүнээс олгогдсон	39,263,400.00
Үлдэгдэл санхүүжилт	39,263,400.00		
Барьцаа	байхгүй		
Нийт	78,526,800.00		39,263,400.00

Гэрээний биелэлт, шийдвэрлэлт

Гэрээний биелэлт	Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын нутаг дахь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 28,000 га талбайд археологийн нарийвчилсан хайгуул, судалгааны ажлыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасны дагуу Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан 4 боть нийт 2194 хуудас тайланг монгол, англи хэл дээр ажил хүлээлцэх актын дагуу хүлээлгэн өгсөн.
Шийдвэр	Захиалагч талын санхүүжилт гэрээнд заасан хугацаанд Гүйцэтгэгч талд олгогдоогүй тул гэрээ дуусах хугацааг 2022 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгахаар талууд тохиролцов. 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр ажил хүлээлцэх акт үйлдэж дээрх ажлыг хүлээж авсан тул №АҮГ-2022/42 тоот гэрээний эцсийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчид олгохоор шийдвэрлэв.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Захиалагч талыг төлөөлж:

Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн
Нэгжийн Гэрээ хэлцэл, Байгаль орчин,
нийгмийн асуудал хариуцсан ажилтан

Гүйцэтгэгч тал:

ШУА-ийн Археологийн
хүрээлэнгийн эрдэмтэн
нарийн бичгийн дарга

..... Д.Бямбацэрэн
Утас: 77551516, 99085599

Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн
нэгжийн Санхүүгийн ажилтан

..... Б.Отгон

Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн
нэгжийн Зохицуулагч

..... Ч. Гантулга

..... Н.Эрдэнэ-Очир
Утас: 11-452894, 91069595

ШУА-ийн Археологийн
хүрээлэнгийн нягтлан бодогч

..... Д.Бадамханд

ШУА-ийн Археологийн
хүрээлэнгийн захирал

..... Г.Эрэгзэн

АЖИЛ ХҮЛЭЭЖ АВСАН ТУХАЙ АКТ

2022 оны 07 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Гүйцэтгэгч: Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн

Гүйцэтгэсэн ажил: “Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх улсын тусгай хэрэгцээний 28000 га газарт археологийн нарийвчилсан хайгуул, судалгааны ажил гүйцэтгэсэн.

Гүйцэтгэсэн хугацаа: 2022 оны 05-р сарын 29-өөс 06-р сарын 20.

Хүлээж авсан материал. Үүнд:

Төслийн бүтээн байгуулалт, үр өгөөж, бодлого, зорилгын талаарх 11 ширхэг хэвлэл мэдээний контент бэлтгэсэн.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдын заагт баригдах “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор улсын тусгай хэрэгцээнд авсан 28 000 (хорин найман мянга) га талбайд археологийн хайгуул судалгааг гүйцэтгэж 4 боть тайланг монгол, англи хэлээр хүлээлгэн өгөв. Үүнд:

*Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан.
Монгол хэлээр*

1. Г.Эрэгзэн, Н.Эрдэнэ-Очир, Б.Анхбаяр, Т.Батбаяр, Л.Эрдэнэболд, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ, Г.Батболд, Г.Цэнгүүн, Б.Буян-Орших, М.Алтаншагай, Ц.Бямба-Эрдэнэ, Э.Түвшин, М.Нямхүү. “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн тусгай хэрэгцээний талбай (Увс аймгийн Өмнөговь сумын нутагт хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан). Боть I. - УБ., 2022. - 894 тал. АХНСА.

2. Г.Эрэгзэн, Н.Эрдэнэ-Очир, Б.Анхбаяр, Т.Батбаяр, Л.Эрдэнэболд, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ, Г.Батболд, Г.Цэнгүүн, Б.Буян-Орших, М.Алтаншагай, Ц.Бямба-Эрдэнэ, Э.Түвшин, М.Нямхүү. “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн тусгай хэрэгцээний талбай (Ховд аймгийн Мянгад сумын нутагт хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан). Боть II. - УБ., 2022. - 197 тал. АХНСА.

3. Г.Эрэгзэн, Н.Эрдэнэ-Очир, Б.Анхбаяр, Т.Батбаяр, Л.Эрдэнэболд, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ, Г.Батболд, Г.Цэнгүүн, Б.Буян-Орших, М.Алтаншагай, Ц.Бямба-Эрдэнэ, Э.Түвшин, М.Нямхүү. “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн тусгай хэрэгцээний талбай (Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан). Боть III. - УБ., 2022. - 75 тал. АХНСА.

4. Г.Эрэгзэн, Н.Эрдэнэ-Очир, Б.Анхбаяр, Т.Батбаяр, Л.Эрдэнэболд, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ, Г.Батболд, Г.Цэнгүүн, Б.Буян-Орших, М.Алтаншагай, Ц.Бямба-Эрдэнэ, Э.Түвшин, М.Нямхүү. “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн тусгай хэрэгцээний талбай (Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутагт хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан). Боть IV. - УБ., 2022. - 1028 тал. АХНСА.

*Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан.
Англи хэлээр*

